

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-29

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 30-88

1. Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх	31-34
2. “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	34-60
3. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	60-61
4. “Жамсрангийн Самбууугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн оиг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	61-63
5. Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай/	63-66
6. Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай/	66-67
7. Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	67-88

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны төвч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 56 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Амарсайхан, С.Бямбацогт, Л.Мөнхбаатар, Б.Пүрэвдорж, Л.Оюун-Эрдэнэ, С.Зул phar, Л.Гантөмөр, Э.Одбаяр, О.Цогтгэрэл.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ хэлэлцэх асуудлын дарааллын зургаадугаар асуудал болох Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг хуулийн төслийг өргөн бариагүй байгаа тухай мэдэгдэж, уг асуудлыг хойшилуулав./13:59/

Нэг. Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Байнгын хороодын ажлын албаны ахлах мэргэжилтэн А.Наранцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ иргэн Насантогтохын Анхзаяагаас 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр цахим системд ирүүлсэн нийтийн өргөдөл болон “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэхтэй холбоотойгоор байгуулагдах ажлын хэсгийн ахлагчаар ажиллах горимын санал гаргав.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалаас Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн

өргөдлийг хэлэлцэхтэй холбоотойгоор байгуулагдах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах тухай бичгээр ирүүлсэн саналыг танилцуулав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 11
Бүгд: 15
26.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, Б.Баярбаатар, Э.Болормаа, Ж.Золжаргал нар орж ажиллахаар тогтов.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Ж.Бат-Эрдэнэ: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 10
Бүгд: 15
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Үг асуудлыг 14 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалт, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, мөн яамны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, мөн газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан, Нийслэлийн Ерөнхий архитектор Ч.Төгсдэлгэр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын, Нийслэлийн Бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Хадбаатар, мөн газрын Хууль, тогтоомж, эрх зүйн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Баялагцэнгэл, Хот байгуулалт, хотын стандартын газрын Ерөнхий архитекторын ажлын албаны дарга А.Баттөмөр, мөн албаны ахлах мэргэжилтэн Ц.Мягмарсүрэн, Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтсийн Дагуул хотын хуулийн асуудал хариуцсан ахлах ажилтан С.Энхжаргал, Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Оюунтуяа, мөн хэлтсийн Ус хангамж ариутгах татуурга хариуцсан мэргэжилтэн Б.Цэрэннадмид, “Хот төлөвлөлт, судалгааны институт” Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга Р.Амартувшин, мөн газрын Ерөнхий инженер О.Одбаяр, зөвлөх архитектор Л.Ганбат, зөвлөх эдийн засагч С.Отгонбаяр, Ерөнхий менежер Л.Эрдэнэбат, Эдийн засагч П.Энхболд, Хяналт, судалгаа мониторингийн хэлтсийн дарга Г.Уранбайгаль, Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга Т.Тэлмэн, Зам, тээврийн судалгаа төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Анхбаяр, Дэд бүтцийн хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Гамшигийн менежментийн зөвлөх Д.Содномрагчаа, Хог хаягдлын менежментийн зөвлөх С.Аригун, Дулаан хангамжийн зөвлөх инженер А.Цогт, Сэргээгдэх эрчим хүчний зөвлөх инженер Б.Мөнхбаяр, Инженерийн бэлтгэл арга хэмжээний зөвлөх инженер Г.Нансалмаа, Мэдээлэл холбооны зөвлөх инженер Ж.Наранцэцэг, Цахилгаан хангамжийн зөвлөх инженер Ж.Сарайдамба, Автомамын зөвлөх инженер Ч.Намшир, Захиргаа менежментийн хэлтсийн дарга Х.Мөнхнаран, Хот төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Сайнтоогох, Байгаль орчны зөвлөх З.Батжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогох, Байнгын хороодын ажлын албаны ахлах мэргэжилтэн А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Барилга, хот байгуулалт, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Θ.Шижир, Ц.Сандаг-Очир, П.Сайнзориг, Ж.Алдаржавхлан, Ж.Бат-Эрдэнэ, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Ц.Сандаг-Очир, П.Сайнзориг, Х.Ганхуяг, Г.Лувсанжамц, Ж.Бат-Эрдэнэ нар уг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гараг санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Итгэлт, мөн газрын Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Д.Мөнхбат, Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, мөн хэлтсийн ахлах шинжээч Б.Цэнд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Байнгын хороодын ажлын албаны ахлах мэргэжилтэн А.Наранцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэв.

Тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гараг санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.“Жамсрангийн Самбуутийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Байнгын хороодын ажлын албаны ахлах мэргэжилтэн А.Наранцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Үг асуудлыг 15 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Байнгын хороодын ажлын албаны ахлах мэргэжилтэн А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Л.Мөнхбаатараас ирүүлсэн саналыг танилцуулав.

Ж.Бат-Эрдэнэ: “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Л.Мөнхбаатараас ирүүлсэн 2 саналыг нэмэх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7

Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн **Н.Учралын** “дэмжсэн” санал техникийн saatlyin улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Үг асуудлыг 16 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Анар-Эрдэнэ Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Байнгын хороодын ажлын албаны референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	7
Бүгд:	15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Үг асуудлыг 16 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, мөн газрын Дэд дарга Б.Батцэцэг, Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Н.Нацагдорж, мөн захиргааны зөвлөх Б.Энхсайхан, Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Амарсанаа, хуулийн мэргэжилтэн М.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 11, 22, 31, 35 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, Ч.Анар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Д.Бум-Очир, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Д.Жаргалсайхан, С.Замира, Б.Заябал, Г.Лувсанжамц, С.Лүндэг, П.Мөнхтулга, Б.Найдалаа, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг, С.Эрдэнэболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн гарчгийн “ХОТЫН” гэсний дараа “ТӨЛӨВЛӨЛТ,” гэж нэмж, үүнтэй холбогдуулан төслийн 6 дугаар бүлгийн, 26 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 26.1 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот төлөвлөлт” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь түүхэн нийслэл Хархорум хотыг сэргээн байгуулж, монгол үндэстний түүх, язгуур өв, нүүдлийн соёл иргэншлийг хамгаалах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, байгаль орчинд ээлтэй, хүний ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжих, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь түүхэн нийслэл Хархорум хотыг сэргээн байгуулж, монгол үндэстний түүх, язгуур өв, нүүдлийн соёл иргэншлийг хамгаалах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, байгаль орчинд ээлтэй, хүний ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжих,

эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	6
Бүгд:	15
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

Ж.Бат-Эрдэнэ: 3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль,” гэсний дараа “Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	7
Бүгд:	15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	7
Бүгд:	15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим

4.1.Хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжихэд Хот байгуулалтын тухай хуулийн 4.1-д зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

4.1.1.Монгол үндэстэн, угсаатны уламжлалт үнэт зүйл, түүх, соёлын биет болон биет бус өвийг сэргээх, хадгалан хамгаалах;

4.1.2.түүх, соёлын дурсгалт газар, археологи, соёлын биет болон биет бус өв, байгалийн онцлог, нүүдлийн соёл иргэншилд түшиглэн олон төрөлт тогтвортой аялал жуулчлалыг дэмжих;

4.1.3.бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангаж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдсан, эдийн засгийн хувьд Хангайн бүсийн хөгжлийг дэмжих, бие даан хөгжих боломжтой байх;

4.1.4.тогтвортой хөгжлийн зорилгыг хангах хөрөнгө оруулалтыг дэмжих;

4.1.5.хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, үйл ажиллагаа оршин суугчийн нийтлэг эрх, ашиг сонирхолд нийцсэн, нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, хүмүүнлэг, олон төвт хотын тогтолцоог хөгжүүлэх;

4.1.6.дэвшилтэт технологи, инновацад суурилсан, ухаалаг дэд бүтцийг хөгжүүлэх;

4.1.7.эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийг дэмжих,

4.1.8.сэргээгдэх эрчим хүчний олон төрлийг дэмжих;

4.1.9.орчны аюулгүй байдлыг хангаж, гамшгаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.10.Улаанбаатар хот болон бусад бүс нутагтай холбогдох зорчигч болон ачаа тээврийн сүлжээг хөгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 6

Бүгд: 15

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Хотын эрх зүйн үндэс

5.1.Хот нь улсын зэрэглэлтэй байна.

5.2.Хотын захирагч хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хотыг төлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.Хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох, түүнийг өөрчлөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэх бөгөөд Газрын тухай хуульд заасан эдэлбэр газрын хэмжээ, заагийг баталж, тогтоохтой холбогдох зохицуулалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Хот нь” гэсний дараа “Хот байгуулалтын тухай хуулийн 11.1-д зааснаас гадна” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “өөрчлөлт оруулах” гэсний дараа “асуудал болон хэрэгжүүлэх дэд бүтцийн төслүүдийн жагсаалтыг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг 7.4, 7.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

7.4.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн бүтээн байгуулалтын үе шат бүрээр хамт боловсруулах бөгөөд хотын Зөвлөл батална.

7.5.Төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг 7.4, 7.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

7.4.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн бүтээн байгуулалтын үе шат бүрээр хамт боловсруулах бөгөөд хотын Зөвлөл батална.

7.5.Төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Θ.Шижирийн “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Θ.Шижирийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг 7.4, 7.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

7.4.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн бүтээн байгуулалтын үе шат бүрээр хамт боловсруулах бөгөөд хотын Зөвлөл батална.

7.5.Төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “зориулалтаас” гэснийг “зориулалт, хүн амын нягтаршлаас” гэж, 8.1.3 дахь заалтын “1 га” гэснийг “0.1 га” гэж, 8.1.5 дахь заалтын “нягтралыг” гэснийг “нягтаршлыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийн түвшинд” гэж, 8.1.6 дахь заалтын “төлөвлөгөөний шийдэл, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай” гэснийг “баримт бичгүүдтэй” гэж, 8.1.2 дахь заалтын “ногоон хот байгуулах зорилтын хүрээнд” гэснийг “хотын” гэж, 8.1.8 дахь заалтын “байгууламжийн хамт цогцоор нь төлөвлөсөн” гэснийг “байгууламж, инженерийн дэд бүтцийн зурвасыг багтаасан цогц төлөвлөлтөөр шийдсэн” гэж, 8.2 дахь хэсгийн “ухаалаг шийдэл нэвтрүүлнэ” гэснийг “олон улсын ухаалаг хотын стандартад заасан ухаалаг шийдлийг нэвтрүүлж болно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “зориулалтаас” гэснийг “зориулалт, хүн амын нягтаршлаас” гэж, 8.1.3 дахь заалтын “1 га” гэснийг “0.1 га” гэж, 8.1.5 дахь заалтын “нягтралыг” гэснийг “нягтаршлыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийн түвшинд” гэж, 8.1.6 дахь заалтын “төлөвлөгөөний шийдэл, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай” гэснийг “баримт бичгүүдтэй” гэж, 8.1.2 дахь заалтын “ногоон хот байгуулах зорилтын хүрээнд” гэснийг “хотын” гэж, 8.1.8 дахь заалтын “байгууламжийн хамт цогцоор нь төлөвлөсөн” гэснийг “байгууламж, инженерийн дэд бүтцийн зурвасыг багтаасан цогц төлөвлөлтөөр шийдсэн” гэж, 8.2 дахь хэсгийн “ухаалаг шийдэл нэвтрүүлнэ” гэснийг “олон улсын ухаалаг хотын стандартад заасан ухаалаг шийдлийг нэвтрүүлж болно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “орон сууцнаас” гэсний өмнө “нийтийн” гэж, 8.1.7 дахь заалтын “шийдэл нь” гэсний дараа “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгасан гудамжны нийтлэг өнгө, барилгын өндөржилт, загварын дагуу” гэж, 8.1.9 дэх заалтын “саарал усыг” гэсний

өмнө “хотын олон нийтийн барилга байгууламж нь” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “орон сууцнаас” гэсний өмнө “нийтийн” гэж, 8.1.7 дахь заалтын “шийдэл нь” гэсний дараа “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгасан гудамжны нийтлэг өнгө, барилгын өндөржилт, загварын дагуу” гэж, 8.1.9 дэх заалтын “саарал усыг” гэсний өмнө “хотын олон нийтийн барилга байгууламж нь” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.15 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.1.18, 8.1.19 дэх заалт нэмэх:

“8.1.18.байгаль экологи, археологи, палеонтологи, нүүдлийн өв, соёл, нутгийн иргэдийн ахуй амьдралд түшиглэсэн, төрөлжсөн аялал жуулчлалыг хөгжүүлэх;

8.1.19.түүх, соёлын дурсгал, урлагийн бүтээлд тулгуурлан үндэсний бахархлыг сэргээж, биет болон биет бус өвийг хадгалан хамгаалах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.3 дахь хэсэг нэмэх:

“8.3.Хотын ерөнхий төлөвлөгөөг 20 жил, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 5 жилийн хугацаатайгаар төлөвлөх бөгөөд оршин суугч болон аж ахуйн нэгжийн санал, барилгажилтын түвшин, хотын Зөвлөлийн олонхын шийдвэрийг үндэслэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Хотын нутаг дэвсгэрийн бүсчлэл

9.1.Хотын нутаг дэвсгэр Хот байгуулалтын тухай хуулийн 13.1-д зааснаас гадна дараах бүсчлэлтэй байх бөгөөд эдгээр бүсүүд нь тусгайлан баталсан бүсчлэлийн дүрэмтэй байна:

- 9.1.1.археологи судалгааны бүс;
- 9.1.2.нийгмийн дэд бүтцийн бүс;
- 9.1.3.тээвэр, логистикийн бүс;
- 9.1.4.инженерийн дэд бүтцийн бүс;
- 9.1.5.хамгаалалтын бүс;
- 9.1.6.холимог ашиглалтын бүс;
- 9.1.7.нөөц бүс /цагаан газар/.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан бүсчлэлийн дүрмийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр нарийвчлан тодорхойлно.

9.3.Бүсчлэлийн дүрэмд тухайн бүсэд зөвшөөрөгдөх үйл ажиллагааны төрөл, барилга байгууламжийн хэмжээ, байршил, барьж болох барилгын зориулалтыг тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.5 дахь хэсгийн “эзэмших,” гэснийг тус тус, 10.3 дахь хэсгийн “ашиглуулахаас” гэсний өмнөх, мөн хэсгийн “ашиглуулах” гэсний өмнөх, 16 дугаар зүйлийн 16.7.6 дахь хэсгийн “эзэмшүүлэх,” гэснийг тус тус хасаж, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 14
Бүгд: 16
12.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “төсөл сонгон шалгаруулах журмаар шийдвэрлэнэ.” гэснийг “дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.5.1 дэх хэсгийн “заасан бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхээс” гэснийг “зааснаас” гэж, 10.5.2 дахь заалтын “бүтээн байгуулалтын төслийг” гэснийг “газар ашиглах” гэж, “төлөвлөгөөнд” гэснийг “төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөнд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн **Н.Учралын** “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эрсэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.5.1 дэх хэсгийн “заасан бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхээс” гэснийг “зааснаас” гэж, 10.5.2 дахь заалтын “бүтээн байгуулалтын төслийг” гэснийг “газар ашиглах” гэж, “төлөвлөгөөнд” гэснийг “төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөнд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар бүлгийн гарчгийг “ХОТЫН ЧИГ ҮҮРЭГ, УДИРДЛАГА” гэж өөрчилж, 12 дугаар зүйлийн 12.1.12 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 35 дугаар зүйлийг хасах:

“14 дүгээр зүйл.Хотын удирдлага

14.1.Хотын удирдлагыг хотын Зөвлөл, Захирагч хэрэгжүүлнэ.

14.2.Хотын байнгын оршин суугчийн тоо 10000 хүрснээр хотын Зөвлөл, Захирагчийн сонгуулийг зохион байгуулна.

14.3.Энэ хуулийн 14.2-т заасан Зөвлөл, Захирагчийн бүрэн эрх хэрэгжиж эхлэх хүртэл энэ хуулийн 14.6, 14.7-д заасны дагуу томилогдсон Зөвлөл, Захирагч хотын удирдлагыг хэрэгжүүлнэ.

14.4.Энэ хуулийн 14.6, 14.7-д заасны дагуу томилогдсон Зөвлөл, Захирагч Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон энэ хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14.5.Зөвлөл нь 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах төлөөллөөс бүрдэнэ:

14.5.1.Засгийн газрын санал болгосон гурван төлөөлөл;

14.5.2.энэ хуулийн 14.7-д заасан Захирагч;

14.5.3.Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас санал болгосон гурван төлөөлөл;

14.5.4.хот байршиж байгаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга;

14.5.5.барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон мэргэжлийн холбоодын хоёр төлөөлөл.

14.6. Энэ хуулийн 14.5.3-д заасан төлөөллийг нээлттэй нэр дэвшүүлж, тэдгээрээс сонгогдсон гишүүдийг энэ хуулийн 14.5-д заасан бусад гишүүдийн хамт Засгийн газар томилж, чөлөөлнө.

14.7. Энэ хуулийн 14.3-т заасан Захирагчийг Засгийн газар томилж, чөлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	7
Бүгд:	13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.	

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	5
Бүгд:	13
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.	

Ж.Бат-Эрдэнэ: 22. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 35 дугаар зүйлийг хасах:

“14 дүгээр зүйл.Хотын удирдлага

14.1. Хотын удирдлагыг хотын Зөвлөл, Захирагч хэрэгжүүлнэ.

14.2. Хотын байнгын оршин суугчийн тоо 10000 хүрснээр хотын Зөвлөл, Захирагчийн сонгуулийг зохион байгуулна.

14.3. Энэ хуулийн 14.2-т заасан Зөвлөл, Захирагчийн бүрэн эрх хэрэгжиж эхлэх хүртэл энэ хуулийн 14.6, 14.7-д заасны дагуу томилогдсон Зөвлөл, Захирагч хотын удирдлагыг хэрэгжүүлнэ.

14.4. Энэ хуулийн 14.6, 14.7-д заасны дагуу томилогдсон Зөвлөл, Захирагч Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон энэ хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14.5. Зөвлөл нь 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах төлөөллөөс бүрдэнэ:

14.5.1. Засгийн газрын санал болгосон гурван төлөөлөл;

14.5.2.энэ хуулийн 14.7-д заасан Захирагч;

14.5.3.Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас санал болгосон гурван төлөөлөл;

14.5.4.хот байршиж байгаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга;

14.5.5.барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон мэргэжлийн холбоодын хоёр төлөөлөл.

14.6.Энэ хуулийн 14.5.3-д заасан төлөөллийг нээлттэй нэр дэвшүүлж, тэдгээрээс сонгогдсон гишүүдийг энэ хуулийн 14.5-д заасан бусад гишүүдийн хамт Засгийн газар томилж, чөлөөлнө.

14.7.Энэ хуулийн 14.3-т заасан Захирагчийг Засгийн газар томилж, чөлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	6
Бүгд:	13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.	

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “зөвлөл, түүний” гэснийг “зөвлөлийн” гэж өөрчилж, мөн зүйлийн 15.2, 15.3, 15.4, 15.5, 15.6 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	5
Бүгд:	13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.	

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлж, саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5 дахь хэсгийг хасаж, 16.6 дахь хэсгийн “алба болон харьяа газрын” гэснийг “албаны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан нар хариулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	8
Бүгд:	13
38.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.	

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1-ийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлж, дээрх саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.4 дэх заалтын “батлах” гэснийг “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу байгаа эсэхийг шалгах” гэж, 16.7.7 дахь хэсгийн “төлөвлөлтийн даалгаврыг батлах” гэснийг “төлөвлөлтийг хянан зөвшилцэх” гэж, 16.7.9 дэх заалтын “барилга байгууламжийн” гэснийг “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилга байгууламжийн” гэж, мөн заалтын “уялдуулан батлах” гэснийг “уялдаж байгаа эсэхийг хянах” гэж, 16.7.11 дэх хэсгийн “батлах” гэснийг “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу холбогдох байгууллагын дүгнэлтийн дагуу олгох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.13 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.6 дахь заалтын “бүсчлэл” гэснийг “бүсчлэлийн дүрэм” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6

Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.15 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “төлөвлөгөө,” гэсний дараа “бүсчлэлийн дүрэм,” гэж, 17.1.7 дахь заалтын “хот хөгжүүлэх” гэсний дараа “болон хотын дэд бүтцийн” гэж нэмж, 17.1.8 дахь заалтын “энэ хуулийн 29.1.2-т заасан” гэснийг “хотын өмчит болон хотын өмчийн оролцоотой” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 17.1.6 дахь заалтын “бүтээн байгуулалтын” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.1.Энэ хуулийн 18.2-т заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.2.5, 18.2.6, 18.2.14 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “хот хөгжүүлэх” гэсний дараа “сан, хотын дэд бүтцийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн “паркийг” гэснийг “парк, гаалийн тусгай бүсийг” гэж, мөн хэсгийн “заасан журмын дагуу” гэснийг “заасны дагуу” гэж өөрчилж, 23.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	6
Бүгд:	13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.	

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “Зөвлөлийн шийдвэрээр” гэснийг “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1.8-д заасны дагуу” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	6
Бүгд:	13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.	

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.1.3.хотын өмчит болон хотын өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хотод ногдох ногдол ашгийн 10 хүртэлх хувь;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	5
Бүгд:	13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.	

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.4, 25.1.5, 25.1.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	6
Бүгд:	13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.	

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.2.1 дэх заалтын “инженерийн болон” гэснийг хасаж, 25.2.2 дахь заалтын “түүх, соёлын” гэсний дараа “өвийг хадгалан хамгаалах,” гэж, 25.3 дахь хэсгийн “санг байгуулах” гэсний дараа “түүний удирдлага, зохион байгуулалт,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	5
Бүгд:	13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.	

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “эх үүсвэрээр” гэсний дараа “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.5 дахь хэсэг нэмэх:

“27.5.Хөрөнгө оруулалтын хэлбэр, татварын болон татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн эхний өгүүлбэрийг “28.1.Хотод хэрэгжүүлэх төсөл нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 16.1.2, 16.1.3, 16.1.4-т заасан шалгуур хангасан тохиолдолд дараах хугацаагаар тогтвортжуулалтын гэрчилгээг олгоно:” гэж, 28.6 дахь хэсгийн “өөрөөр заагаагүй бол” гэснийг “заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 28.7 дахь хэсэг нэмэх:

“28.7.Хотод үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээртэй хамтран ажиллах зорилгоор хөрөнгө оруулагчдын төлөөллөөс бүрдсэн Хөрөнгө оруулагчдын зөвлөлийг хотын Захирагчийн дэргэд байгуулах ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хотын Зөвлөл батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5

Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн гарчгийн “этгээдийн” гэсний дараа “эрх,” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.1 дэх хэсэг нэмэх:

“33.1.Хот төлөвлөлтийн бичиг баримтаар зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр бүсчлэлийн дүрмийн дагуу хэрэгжүүлэх эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн “Иргэний хуульд” гэснийг, мөн зүйлийн 34.3, 34.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.1.Энэ хуулийг 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн энэ хуулийн 14.2-т заасан нөхцөл бүрдэж, хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Ж.Бат-Эрдэнэ: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, Ч.Анар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Д.Бум-Очир, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Д.Жаргалсайхан, С.Замира, Б.Заяабал, Г.Лувсанжамц, С.Лүндэг, П.Мөнхтүлга, Б.Найдалаа, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа, Г.Үянгахишиг, Г.Хосбаяр, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг, С.Эрдэнэболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн З дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “бүтээн байгуулах” гэсний өмнө “төлөвлөх,” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалтын “нийтийн” гэсний өмнө “олон” гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “бүтээн байгуулалт” гэсний өмнө “төлөвлөлт” гэж, 10 дугаар зүйлийн 10.1, 10.6 дахь хэсгийн, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь хэсгийн “хөгжлийн” гэсний дараа “ерөнхий төлөвлөгөө” гэж, 10 дугаар зүйлийн 10.5.2 дахь заалтын “хэрэгжүүлж” гэсний өмнө “төслийг” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “чиг үүргээс” гэсний өмнө “нийтлэг” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “Засгийн хуралдаанд” гэснийг “Засгийн газарт” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.14 дэх заалтын “нийтийн үйлчилгээний” гэснийг “олон нийтийн” гэж, 10.7 дахь хэсгийн “үүсэн” гэснийг “үүссэн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “гүйцэтгэнэ” гэснийг “хэрэгжүүлнэ” гэж, 15 дугаар зүйлийн гарчгийн “зөвлөл, түүний” гэснийг “зөвлөлийн” гэж, 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийн “бүрэн эрхийг” гэснийг “эрх, үүргийг” гэж, 16.7.18 дахь хэсгийн “10.4” гэснийг “10.3” гэж, 18 дугаар зүйлийн 18.2.3, 18.2.4 дэх хэсгийн “байгууламж,” гэснийг “байгууламжийн” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “үйлдвэр” гэснийг “үйлдвэрлэл,” гэж, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “тогтвортжуулалтын” гэснийг “тогтвортжуулах” гэж, мөн хэсгийн “зохицуулаагүйгээс” гэснийг “зохицуулснаас” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

2. Хот, тосгоны эрх зүй байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: 1. Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, Ч.Анар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Д.Бум-Очир, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Д.Жаргалсайхан, С.Замира, Б.Заябал, Г.Лувсанжамц, С.Лүндэг, П.Мөнхтулга, Б.Найдалаа, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг, С.Эрдэнэболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Нэг. Улсын зэрэглэлтэй хот” гэсэн хэсгийн 4 дэх заалтыг бүхэлд нь хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	5
Бүгд:	13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.	

3. “Хархорум хотын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: 1. Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, Ч.Анар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Д.Бум-Очир, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Д.Жаргалсайхан, С.Замира, Б.Заябал, Г.Лувсанжамц, С.Лүндэг, П.Мөнхтулга, Б.Найдалаа, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг, С.Эрдэнэболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн гарчийг “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” гэж өөрчилж, тогтоолын үндэслэх хэсгээс “, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь” гэснийг хасаж, төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1."Хархорум" хотын бүтээн байгуулалтын үйл ажиллагааг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн зохион байгуулах;

2."Шинэ Хархорум" хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны төсөв, хөрөнгө, эрх, үүрэг, бүтэц бүрэлдэхүүнийг Хархорум хотын Захирагчийн ажлын албанад шилжүүлэх." гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дэх заалтыг хасаж, үүнтэй холбогдуулан тус заалтыг агуулгыг алдагдуулахгүйгээр "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4."Хархорин хотын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

5."Хархорум хотын эдэлбэр газрын хил, заагийг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл, заалт бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Үг асуудлыг 17 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 52 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлийн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
13 цаг 56 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг та бүхэнд танилцуулья. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн байна. Батын Батбаатар гишүүн ирсэн. Энхболдын Болормаа гишүүн ирсэн. Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн. Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн. Даашэвэгийн Амарбаясгалан гишүүн ирсэн. Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн. Тогмидын Доржханд гишүүн ирсэн. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн. Жудагийн Баярмаа гишүүн ирсэн. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулья. Хэлэлцэх асуудал,

Нэг.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх.

Хоёр.“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн өрөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2025 оны 1 сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2024 оны 12 сарын 25-ны өдөр мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.

4.“Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024 оны 12 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг,

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал.

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Засгийн газар 2024 оны 12 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг гэсэн асуудлуудыг өнөөдөр хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг хасъя гэсэн санал гаргаж байна. Хууль нь өргөн баригдаагүй байгаад байна. Энэ өргөн баригдана гээд л оруулсан юм. Тэгээд л хэлэлцэх асуудлууд чинь бид нар чинь бага байгаа шүү дээ. Тийм болохоор оруульяа гээд оруулсан юм. Өргөн баригдаагүй тул энэ асуудлыг хойшлуульяа. Хэлэлцэх асуудалдаа орьё.

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг авч хэлэлцье.

Нийтийн өргөдлийн мэдээллийг та бүхэнд танилцуулъяа.

Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар иргэдээс өргөдөл ирүүлэх Ди өргөдөл parliament.mn цахим системд иргэн Н.Анхзаяагаас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс Нарансэвстийн боомтыг сэргээж, нээх гэсэн хэсгийг хасуулах асуудлаар ажлын хэсэг байгуулан Улсын Их Хурлын хурлаар хэлэлцүүлэх тухай өргөдлийг 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 15 цаг 43 минут 59 секундэд ирүүлсэн байна. 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 18 цаг 24 минут 21 секундэд нийтийн санал авахаар цахим системд нийтэлсэн байна.

Тус нийтийн өргөдлийг 2025 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн байдлаар нийт 33037 иргэн дэмжсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39.4.3-д заасны дагуу ажлын хэсэг байгуулах хуулийн шаардлага хангагдсан байна гэж үзэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.4-д нийтийн өргөдлийг цахим системд 30 хоногийн хугацаатай байршуулах ба уг өргөдлийг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэдийн дэмжсэн санал дараах тоонд хүрсэн тохиолдолд Улсын Их Хурал авч хэлэлцэнэ гэж, 39.4.3-д тодорхой асуудлаар хэлэлцэх асуудлаар Ажлын хэсэг байгуулах саналыг 33 мянга ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол ажлын хэсэг байгуулахаар зохицуулсан байгаа.

Тийм болохоор энд ажлын хэсэг байгуулах шаардлага гарч ирж байна гэж.

Ажлын хэсэг байгуулах тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр “Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.3 дахь заалтыг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос тогтоох нь:

Нийтийн өргөдлийн цахим системд иргэн Насантотгоын Аззаяагийн 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр санаачилсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад 3.3.2.8-д “Нарансэвстэйн боомтыг сэргээж, нээнэ” гэсэн заалтыг хасуулах талаар гаргасан саналыг 33047 иргэн дэмжсэн тул уг саналыг судлан үзэж, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай гэж.

Ажлын хэсгийг Ж.Бат-Эрдэнэ миний бие ахлаад ажиллай гэсэн ийм саналыг оруулж ирж байна. Ажлын хэсгийн гишүүнээр Батын Батбаатар гишүүн ажлын хэсэгт орьё гэсэн ийм саналыг гаргасан байгаа. Өөр ажлын хэсэгт орох саналтай гишүүд байна уу?

Баярбаатар гишүүн. Тойргийн хамааралтай гишүүн. Ер нь 5 гишүүнтэй байгуулчихвал яах вэ, болчих уу? Тэгвэл тоо баталчихъя тэгэх үү? 5 гишүүнээр. 5 гишүүнтэй гэсэн санал. 5 гишүүнээр баталчихъя. Яадаг юм? Үгүй үгүй 5 гишүүнээр би тоо батлуулж байна.

Ингээд Ж.Бат-Эрдэнэ, Баярбаатар, Батбаатар, Болормаа өөр орох гишүүн байна уу?

Ийшээ энэ ажлын хэсэгт орох гишүүд саналаараа өөрсдөө орох гишүүд байна уу? Ер нь тэгж таарах байх. Тийм тийм. 1 гишүүн? Байгаа. Тийм Байнгын хорооноос. Пүрэвдорж гишүүнийг өөрөө. Номинчимэг гишүүн ингээд 5 гишүүн оролцуулаад, айн? Батбаатар гишүүн. Батбаатар гишүүний.

Б.Батбаатар: Энэ иргэдийн санаачилгаар 33047 иргэний гарын үсэг зурж дэмжсэн тэр санаачилгаар ажлын хэсэг байгуулагдахаар болж байгаа. Миний миний бие бол тэр 33047 санаачлагч иргэдийн саналыг дэмжих, тэрийг нь судалж үзэх боломжит ямар хэлбэрээр ажиллах вэ гэдэг тухай бодож байгаа учраас, тэр талд нь байгаа учраас засаг талын буюу өнөөдөр батлагдчихсан байгаа талаас Төрийн байгуулалтын байнгын хорооны даргыг ажлын хэсгийн ахлагчаас нэрээ татаад сольж тавьж өгөөсэй гэж бодож байна. Байнгын хорооны дарга ахлаад ингээд юм явахаар бас иргэдийн санаачилга нь хэрэгжихгүй байх вий гэдэг үүднээс энэ саналыг оруулж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэлье. Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Бат-Эрдэнэ танаа гээд Улсын Их Хурлын гишүүн Золжаргал Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал болон асуудалд орсон Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гарсан иргэдийн

өргөдлийг хэлэлцэж шийдвэрлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох хүсэлтэй байгаа тул хүлээн авч, шийдвэрлэж өгнө үү гээд сая саналаа оруулж ирлээ.

Оруулчихъя тийм үү? Тийм тийм. Тэгвэл Номинчимэг гишүүнийг болиод Золоог, Золжаргалыг оруулбал. За яах вэ оруулчихъя оруулчихъя. Хуульд бол их айхтар зөрчсөн юм, болохгүй юм байхгүй шүү дээ.

Санал оруулж ирж байгаа юм байна. Ахалъя гэсэн санал оруулж ирж байгаа юм байна. Батбаатар дарга, гишүүн ахалъя гэсэн санал оруулж ирж байгаа юм байна. Батбаатар даргын оруулсан саналыг, Батбаатар даргаар ахлуулья гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураая, санал хураалт.

Би өөрөө дэмжсэн шүү. 15 гишүүнээс 4 гишүүн дэмжиж, 26.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ингээд “Ажлын хэсгээ байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор. Болормаа гишүүн.

Х.Болормаа: Ажлын хэсгийн байгуулах асуудлыг хэлэлцэж байгаад баярлалаа. Би нөгөө өмнө нь яг энэ дээр бид нар ингэж ажлын хэсэг байгуулж байгаа болохоор юм тодруулж асуух гээд. Ямар ч байсан Байнгын хороо энийг бас маш түргэн авч хэлэлцэж байгаад баярлалаа. 12 сарын 15-ны өдөр анх удаагаа энэ ди парламент дээр гарч ирээд хамгийн сүүлийн санал 1 сарын 5-нд ороод ингээд 10 хоногийн дотор ажлын хэсэг байгуулах ажлыг Төрийн байгуулалтын байнгын хороо оруулж ирж байгаад маш их баярлалаа.

Харин энэ иргэдийнхээ төлөөллийг ажлын хэсэгт оруулах тийм механизм байдаг уу? Яаж энэ дээр үндэслэж яг Төрийн байгуулалтын байнгын хороо дэгийнхээ дагуу энэ иргэдийн төлөөллийг оруулах тийм боломж байдаг уу гэдгийг тодруулах гэсэн юм.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгээ хэдүүлээ ямар ч л байсан Байнгын хорооны асуудлын хүрээнд өөрсдөө ингээд ахлаад явчихъя. Ер нь бол ажлын хэсэг, дэд ажлын хэсэг байгуулж болдог шүү дээ. Дэд ажлын хэсэг байгуулаад зохих мэргэжлийн байгууллагууд яамдаас ажлын хэсгээ оруулаад тэнд санаачилга гаргасан хүмүүс чинь ч орж ирэх байх ингээд явчхаж болно.

Тогтоолын 2 дугаар заалт заалт дээр би түрүүн дутуу уншчихсан юм байна шүү дээ. Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэг Ж.Бат-Эрдэнэд зөвшөөрсүгэй гэсэн ийм 2 дахь заалттай орж ирж байгаа шүү. Тийм.

Тэгээд ер нь ажлын дэд хэсэгт зохих тийм холбогдолтой хүмүүсээ бол оруулаад мэргэжлийн болон бусад хүмүүсийг оролцуулаад явах ийм бололцоотой. Иргэдийг бас оролцуулах бололцоотой.

Ингээд тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

Яасан? Минийх орсон шүү дээ. Энэ гишүүд. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Санал хураалтад оролцохос хоцорчихлоо. Дэмжиж байгаа учир эсрэг санал гарчихлаа. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгож өгч, дахин санал хурааж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүний гаргасан саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын саналын дагуу санал хураалт явуулъя. Хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 15-аас 8 гишүүн оролцож, 53.3 хувиар санал дэмжигдлээ.

Одоо тогтоолоо баталья гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

15-аас 8 гишүүн санал хураалтад оролцож, 53.3 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа. Дараагийн асуудалд оръё.

14.12 цаг

“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг явуулъя.

Төсөл санаачилгын илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга хот байгуулалтын сайд Жамбын Батсуурь танилцуулна. Ажлын хэсгийг оролцуулья. Эхлээд юу ажлын хэсгээ танилцуулах уу?

Жамбын Батсуурь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны сайд, Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засан дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Сүхбаатарын Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цогтын Баярбат Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга, Дагвадоржийн Бэлэгсайхан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч, Чинбатын Төгсдэлгэр Нийслэлийн Ерөнхий архитектур, Пагмажавын Хадбаатар Нийслэлийн Засан даргын Тамгын газар Нийслэлийн Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Дэмбэрэлийн Баялагцэнгэл Нийслэлийн Засан даргын Тамгын газар Хууль тогтоомж, эрх зүйн бодлого зохицуулалтын зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн. Энэ хүмүүс байна уу ер нь? Амгаагийн Баттөмөр Хот байгуулалт, хотын стандарт газрын ерөнхий архитекторын ажлын албаны дарга, Басбишийн Оюунтуяа Хот байгуулалт, хотын стандартын газрын Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга, Даваадашийн Адьяа Хот байгуулалт, хотын стандартын газрын Ерөнхий архитекторын ажлын албаны ахлах мэргэжилтэн, Цэнд-Аюушийн Мягмарсүрэн Хот байгуулалт, хотын стандартын газрын Ерөнхий архитекторын ажлын албаны төсөл, хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн, Сумъяасүрэнгийн Энхжаргал Хот байгуулалт, хотын стандартын газрын Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтсийн Дагуул хотын хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Балжиннямын Цэрэннадмид хот байгуулалт, хотын стандартын газрын Хот байгуулалтын

инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн Ус хангамж ариутгах татуурга хариуцсан мэргэжилтэн. Яасан ч давхар давхар албатай хүмүүс вэ дээ. Ийм олон хүн байгаа юм уу энэ чинь, хэдэн хүн байгаа юм бэ? Бүгд байгаа юм уу? Раднаагийн Амартувшин Хот байгуулалт, судалгааны институтийн дарга. Энэ баахан л юу юу ч гэж байгаа юм бэ дээ. ОНӨАТҮ-ийн дарга Орон нутгийн өмчт, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга, Оюун Одбаяр Хот байгуулалт, судалгааны институтийн саяын газрын Ерөнхий инженер, Лувсанрэнчигийн Ганбат Хот байгуулалт, судалгааны институт зөвлөх архитектур, Сандагдоржийн Отгонбаяр Хот байгуулалт, судалгааны институт зөвлөх эдийн засагч, Лүнгээ Эрдэнэбат Хот байгуулалт, судалгааны институт Ерөнхий инженер, Пүрэвдоржийн Энхболд Хот байгуулалт, судалгааны институт Эдийн засагч, Гонгорын Уранбайгаль Хот байгуулалт, судалгааны институт Хяналт, судалгаа мониторингийн хэлтсийн дарга, Тунгалагтуул Тэлмэн Хот байгуулалт, судалгааны институт Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга, Саруулын Анхбаяр Хот байгуулалт, судалгааны институт Зам, тээвэр, судалгаа төлөвлөлтийн хэлтсийн дарга, Бямбажаргалын Лхагвасүрэн Хот байгуулалт, судалгааны институт Дэд бүтцийн хөгжлийн дарга, Дагвуын Содномрагчаа Хот байгуулалт, судалгааны институт Гамшгийн менежментийн зөвлөх, Саранхүү Аригун Хот байгуулалт, судалгааны институт Хог хаягдлын менежментийн зөвлөх, Аюурзана Цогт Хот байгуулалт, судалгааны институт Дулаан хангамжийн зөвлөх инженер, Буянгийн Мөнхбаяр Хот байгуулалт, судалгааны институт Сэргээгдэх эрчим хүчиний зөвлөх инженер, Гүрсэдийн Нансалмаа Хот байгуулалт, судалгааны институт Инженерийн бэлтгэл арга хэмжээний зөвлөх инженер, Жигмэдийн Наранцэцэг Хот байгуулалт, судалгааны институт Мэдээлэл холбооны зөвлөх инженер, Жигжидсүрэнгийн Сарайдамба Хот байгуулалт, судалгааны институт Цахилгаан хангамжийн зөвлөх инженер, Чойжилын Намшир Хот байгуулалт, судалгааны институт Авто замын зөвлөх инженер, Хадаагийн Мөнхнаран Хот байгуулалт, хот төлөвлөлт судалгааны институт Захиргаа менежментийн хэлтсийн дарга, Лувсанчоймболын Сайнтоогох Хот төлөвлөлт, судалгааны институт Хот төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Замбын Батжаргал Хот төлөвлөлт, судалгааны институт Байгаль орчны зөвлөх.

Бүхэл бүтэн байгууллага тэр чигээрээ л ирчихсэн. Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Жамбын Батсуурь танилцуулна. Батсуурь сайдын микрофоныг өгье.

Ж.Батсуурь: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

НҮБ-ын тооцоолсноор дэлхийн хот, суурин газрын нийт хүн ам 2050 онд 2 дахин өсөж, хотжилтын түвшин 70 хувьд хүрснээр 21 дүгээр зууны өөрчлөлтийн нэг гол чиг хандлага болох төлөвтэй байна. Үүний дотор Ази тивийн хотууд хурдацтай хөгжиж, хотжилтын түвшин дэлхийн бусад хэсгүүдтэй харьцуулахад хамгийн өндөр байгаа нь хүн ам, байгалийн өсөлт ба шилжилт хөдөлгөөний нөлөө харьцангуй их байгаатай холбоотой юм.

2030 он гэхэд Азийн хүн амын 55 гаруй хувь нь хотуудад байх болж олон суурин газрууд нэгдэж, урьд өмнө байгаагүй томоохон суурин газруудыг бий болгон шинээр мэга бус, хот бус гэсэн хэлбэртэйгээр хөгжих болж байна.

Манай улсын хотжилтын түвшин 1990 оноос хойш хөдөөгөөс хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хурдацтай нэмэгдэж 60 гаруй хувьд хүрсэн нь зарим улс орнуудын дунджаас өндөр үзүүлэлт болж байна. Энэхүү үйл явцаас хамааралтайгаар сүүлийн жилүүдэд хотуудын хүн амын өсөлт нэмэгдэж, суурьшлын орон зайд ихээр тэлж байна. Түүнээс нийслэл хотын хүн ам 2023 оны жилийн эцсийн байдлаар 1 сая 735 мянгад хүрч нийслэлийн ДНБ-ий хэмжээ 46.8 их наяд төгрөг буюу үндэсний ДНБ-ий 66.5 хувьтай тэнцэх боллоо.

Ийнхүү Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж, замын хөдөлгөөний түгжрэл, агаар, хөрсний бохирдол, дэд бүтцийн дутагдал зэрэг нь хот байгуулалтад хүндрэл учруулж, иргэдийн ая тухтай, эрүүл аюулгүй амьдрах эрх зөрчигдөхөд хүргэж байгаа нь хотжилтын чиг хандлагад тулгуурлан хөгжлийн бодлого, урт хугацаагаар төлөвлөж, тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд шаардлагатай болоод байгаа юм.

Улсын Их Хурлаас 2021 онд Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2023 онд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, 2024 онд Хот, тосгоны эрх зүйн тухай байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг тус тус баталсан нь Нийслэл хотын төвлөрлийг бууруулах, нэг төвт хотоос олон төвт хот болон хөгжих хууль, эрх зүйн орчин, эдийн засаг, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг бүрдүүлсэн юм. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9.3.1-д Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зайд гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гэж Монгол Улсыг 2021-25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн зорилт 9-д амьдрах таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ гэж, Монгол Улсын Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 20 минутын хот буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын бичиг баримтыг боловсруулж, түүнд суурилсан Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040 болон бусад хот, суурин газрын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулна гэж тус тус заасныг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2025 оны 1 сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн болно.

Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5-д Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын Их Хурал батлахаар заасны дагуу холбогдох тогтоолын төслийг доор дурдсан агуулга бүхий үндсэн 3 заалт, 4 дэд заалттайгаар боловсруулж өргөн барьж байна.

1. Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг хавсралтад заасан бичиглэл болон зураглал, материалын бүрдэлтэйгээр нь батлахаар заасан.

2. Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар дараах арга хэмжээг авахыг даалгасныг тусгав.

Хот байгуулалтын тухай хуулийн 6.5-д заасны дагуу Нийслэлийн хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж түүнд заасан арга хэмжээг улсын болон Нийслэлийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган шаардагдах хөрөнгийг төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөж, үе шаттайгаар хэрэгжүүлэх.

Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн төслийг боловсруулах, Улсын Их Хуралд өргөн барих ажлыг зохион байгуулах.

Урт хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд 5 жил тутамд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Улсын Их Хуралд танилцуулахаар тусгаарлан зааж өгсөн юм.

3. Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр батлахтай холбоотойгоор одоо мөрдөж байгаа Улаанбаатар хотыг 2020 он хүртэлх хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, “2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2013 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хүчингүй болгоно.

Нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг 1954 онд анхан боловсруулснаас хойш 1961, 1976, 1986, 2002 онуудад тодотгол, өөрчлөлт хийсэн бөгөөд өнөөдрийн байдлаар Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэлх хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлж ирсэн нь мөрдөгдөх хугацааны хувьд дуусгавар болсон тул Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөг хот төлөвлөлт, судалгааны институц ОНӨААТҮГ шинээр гүйцэтгүүллээ.

Жаахан байж байхгүй юу. Зэрэгцэж яриад байх юм.

Нийслэлийн хэмжээнд хотуудыг соёл боловсрол, хөдөө аж ахуйн, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр ложистик, эдийн засгийн тусгай бүс, аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлж, 193 мянган ажлын байрыг шинээр бий болгох төдийгүй амьдрах таатай, байгаль орчинд ээлтэй, ухаалаг хотыг хөгжүүлэх үзэл баримтлалын хүрээнд тогтвортой, идэвхтэй, дасан зохицох, цогц хүртээмжтэй байхад чиглэсэн нийт 31 зорилт, 111 дэд зорилт бүхий арга хэмжээг хэрэгжүүлэхээр энэхүү төлөвлөгөөнд тусгалаа.

Тухайлбал, Нийслэлийн нутаг дэвсгэрт 20 минутын хот үзэл баримтлалаар улсын зэрэглэлтэй 2 хот, орон нутгийн зэрэглэлтэй 14 хот, дагуул 4 хотыг төлөвлөн хөгжүүлж Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс, Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүс, Баганур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлт эко үйлдвэрийн паркийг байгуулна гэж оруулж ирж байна. Түүнчлэн гэр хорооллын дахин төлөвлөлтийг эрчимжүүлэн, Сэлбэ, Баянхшуу, Толгойт, Шар хад, Дэнжийн мянга, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн бүтээн байгуулалтыг хийж, хотын нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлж,

42 хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөн оруулж ирлээ.

Мөн Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсын чанартай шинэ тойрог зам, Туулын хурдны авто зам, Өдөө тэмүүлэх Монгол буюу Go Mongolia ган татлагат гүүрний төсөл, их багтаамжийн метро, хөнгөн галт тэрэг, дүүжин тээвэр зэрэг олон төрөлт нийтийн тээврийн шугам сүлжээ байгуулах мега төслүүдийг бодит ажил болгон автомашинтай хотыг өөрчлөхөөр төлөвлөж оруулж ирсэн.

Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд ихээр өртөж байгаа орнуудын нэгд зүй ёсоор орж байгаа бөгөөд энэ нь цөлжилт, хөрсний доройтол, усны хомсдол, дулааны улиралд орох хур тунадасны хэмжээ буурах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрс тэс үзэгдлийн тоо хэмжээ нэмэгдэх зэргээр илэрч байгаа тул Туул усан цогцолбор төслийг хэрэгжүүлж, үерийн эрсдэлээр урьдчилан сэргийлэх Туул, Сэлбэ, Улиастай, Нарангийн голын эргийн хамгаалалтын далан болон ус зайлцуулах суваг хөв, цөөрмийг байгуулахаар энэхүү төлөвлөгөөнд тусгасан болно.

Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулснаар Нийслэл болон Нийслэлийн нутаг дэвсгэр дэх бусад хотууд, дагуул хотуудыг 20 минутын хот үзэл баримтлааар төлөвлөн хүн амын суурьшил, хот байгуулалтын оновчтой бодлогоор хөгжүүлж, иргэдийг оршин суугаа газартаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн, сэргээгдэх эрчим хүч, ухаалаг технологийн хэрэглээнд нэвтрүүлсэн орчны бохирдолгүй, уур амьсгалын өөрчлөлт, сорилтыг даван туулах, дасан зохицох чадвартай, хэмнэлттэй ухаалаг хот болгон хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэхээр энэхүү төлөвлөгөөнд орууллаа.

2. Нийслэл дэх хот, тосгоны эдэлбэр газрын хэмжээ, зааг бүсчлэлийг тогтоосноор хотжих боломжтой нутаг дэвсгэрийн газар ашиглалт сайжирч, хяналттай, төлөвлөлттэй суурьшил үүснэ гэж үзэж байна.

3. Гэр хорооллын байршил, инженерийн дэд бүтцийн сүлжээ, сууцны төрөл зэргээс шалтгаалан төвийн бүс нь төвлөрсөн инженерийн бүсэд холбогдсон өндөр болон дунд давхрын орон сууцын хороолол, дундын бүс нь хэсэгчлэн инженерийн дэд бүсэд холбогдсон нам болон дунд давхаргын орон сууцын хороолол, захын бүс нь бие даасан инженерийн дэд бүтэц бүхий сайжруулсан амины орон сууцын хороолол байхаар төлөвлөж байна.

4. Байгаль орчны тэнцвэрт байдлыг хамгаалж, агаар орчны бохирдлыг бууруулахаар төлөвлөсөн. Тухайлбал, барилгажсан болон гэр хорооллын хэсэг, дэд төвүүдэд хотын болон дүүргийн чанартай цэцэрлэгт хүрээлэнгүүдийг шинээр байгуулснаар 1 хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг 5м2-35м2 болгож, 8 дахин нэмэгдүүлж, иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх тохилог орчныг бүрдүүлэхээр төлөвлөн оруулж ирлээ.

5. Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулж, тухайлбал, метро, LRT зэрэг их багтаамжийн нийтийн тээврийн сүлжээг бий болгож, өдөрт 1.2 сая зорчигч тээвэрлэж, тээвэрлэх нийтийн тээврийн хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлж, мөн 1738.8км замыг шинээр байгуулж, оргил цагийн хөдөлгөөний дундаж хурдыг 9км цагаас 22.5км цаг болгон нэмэгдүүлнэ гэж төлөвлөж байна.

6. Нийслэл Улаанбаатар хот нь нэг төвлөрсөн хотоос олон төвт хотын тогтолцоонд шилжиж, иргэд олон нийтийн нийгмийн болон төрийн үйлчилгээг ойртуулах нөхцөл бүрдүүлнэ.

7-д нь Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, үр дүнг нь тайлагнан ажиллана.

8. Нийслэлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг төр, орон нутаг, хувийн хэвшил, иргэд, олон нийтийн хамтын ажиллагаа оролцоог өргөн хэрэгжүүлж ажиллана. Уг төлөвлөлтийн бичиг баримт, бичиг батлагдан хэрэгжсэнээр хот төлөвлөлтийн шинэ орчныг бүрдүүлэн Нийслэлийн хэмжээнд хот байгуулалтын шинэтгэлийг иж бүрнээр хийхээр тооцсон болно.

Энэхүү тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг эрхэм Байнгын хорооны гишүүд та бүхнээс хүсэж байна.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Ажлын хэсгийн бүх хүмүүс ирсэн байгаа. Та бүхэн Улаанбаатар хотын 6 дахь ерөнхий төлөвлөгөөг хамтарч хийснээр өнөөгийн бидэнд тулгамдаад байгаа агаарын болон хөрсний бохирдол, мөн түгжрэл, өнөөдрийн нийгэмд асуулт болоод байгаа бүхий л зүйлүүдэд энэ ерөнхий төлөвлөгөө хариулт өгөх бүрэн боломжтой гэж ингэж үзэж байгаа.

Эрхэм гишүүд та бүхэнд анхаарал тавьсан явдалд баярлалаа. Бидний тогтоолыг дэмжин баталж өгөхийг хүсэж байна. Анхаарал хандуулсанд.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Маш их зүйл ярилаа. Уг нь 10 минут дотор танилцуулах ёстой тэгээд хэдэн минут болчхов? Ер нь бол энэ ажлын хэсгээ цаашдаа сайд аа яг албадынхаа дарга нарыг дагуулж ирж байвал зүйтэй шүү дээ. Ар талаас шипи өгч байдаг энэ хүмүүсээ ажлыг нь хийлгэмээр байна. Албадын дарга нар бол ажлаа мэддэг байх гэж бодож байна. Тэр утгаараа бүх зүйлээ мэдэж байж хариулах тийм боломж, бололцоотой хүмүүс ажиллаж байгаа байх л гэж бодож байгаа шүү. Тэгэхгүй баахан хүмүүс дагуулж орж ирээд нөгөөдхөө өргэж хараад шипи аваад байдаг ийм ажил, албаны дарга нар байвал тэгээд хэрэггүй л байх гэж харж байгаа шүү.

Ингээд төсөл санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан, төслийн үзэл баримтлалтай холбоотойгоор асуулт асуух бас гишүүд байвал нэрсээ өгнө үү.

2-хон гишүүн үү? Сандаг-Очир гишүүн. Наад ирцдээ орсон юм уу? Хэн хэн байна? Сандаг-Очир гишүүнийг нэмье. Сайнзориг гишүүн, Алдаржавхлан гишүүн. Асуулт асуух гишүүд болсон уу? Алдаржавхлан гишүүнээр хаая. Энэ дээр чинь гарч ирэхгүй байна уу? Энэ яагаад болж өгөхгүй байгаад байна. Энэ Ай Ти-гийнхан үз дээ. Энэ дээр гарч ирэхгүй байна. Тэр хэн гээд байгаа юм? Хэн байна тэр? Хардаггүй. Батбаатар гишүүн үү? Батбаатар гишүүн микрофоныг нээе.

Б.Батбаатар: Батсуурь сайд гармааргүй л байгаа юм уг нь. Дөнгөж дөнгөж танилцуулгаа хийчхээд ингээд гараад явчихвал дэмий байлгүй дээ. Суусан нь дээр байлгүй дээ Батсуурь сайд аа.

Ж.Бат-Эрдэнэ: Таныг суучих гэж байна. Батсуурь сайд аа.

Б.Батбаатар: Тэгвэл асуултаяа хүлээгээд удахгүй байж байя, хүлээж байя.

Ж.Бат-Эрдэнэ: Асуулт танаас асуух гээд байна. Суучих.

Б.Батбаатар: Та гарчхаад ороод ир, тэгээд асуултаяа эхэлье.

Гарчхаад орж ирэхээр нь асуултаяа хэлье. Байсаар байхад нь асууж байхад.

Ж.Бат-Эрдэнэ: Шижир гишүүн.

Ө.Шижир: Өдрийн мэнд Улаанбаатар хот 1954 онд анхны төлөвлөлтөө хийсэн. Түүнээс хойш сая Батсуурь сайдын илтгэл дээр хэлж байгаа нь зургаа дахь дахин төлөвлөлт юм байна.

Хамгийн сүүлд 2002 онд энэ энэний өмнөх буюу 5 дахь ерөнхий төлөвлөгөө батлагдсан. 2002 оноос хойш энэ ерөнхий төлөвлөгөөний дүгнэлт, тайлан гэж юм байдаг уу? Одоо хотын даргаас асууя. Яагаад ингэж сууж байна вэ гэхээр өнөөдөр Улаанбаатар хотод бүтэн биеийн тамирын талбайтай 1 ч сургууль, цэцэрлэг үлдээгүй. Бүгд барилга болсон, бүгд орон сууц болсон, бүгд хувийн хэвшилд шилжсэн, бүгд зарагдсан. Хамгийн бодит, хамгийн энгийн чигт 84 дүгээр сургуулийн яг үүдэнд нь тулгаад 2 ч барилга барьчихсан. Үүнээс улбаалаад хүүхдүүдийн биеийн тамир хичээллэх талбай байхгүй болсон, тоглох орчин байхгүй болсон. Үндсэндээ Улаанбаатар хот өнөөдөр юу болсон бэ гэхээр төлөвлөлтгүй, төлөвлөгөөгүй, зохион байгуулалтгүй, томоос том тосгон болгож орхисон. Бүх юм нь 2-3-хан километр радиус дээр байдаг, төрийн бүх үйлчилгээ нь энэ дотор эргэлддэг. Бүх сургууль нь, бүх төрийн байгууллага нь үйлчилгээ авч болох ёстой бүх төрийн үйлчилгээнүүд нь 2-3-хан километр радиус дээр эргэлддэг. Түгжрэлдээ хахсан, утаандаа хордсон ийм нийслэл болчихсон.

2002 оны саяхны зургуудыг бид нар ингээд харах юм бол Улаанбаатар хотын төлөвлөлт маш гоё байсан. Анхны төлөлт маш гоё байсан. Түүнээс хойш үе үеийн газрын дарга, нар үе үеийн ерөнхий архитектурууд энэ бүгдийг нь ингээд сөнөөчихсэн. Бүүр томоос том тосгон болгочихсон энэ Улаанбаатар хотыг. Тэгээд энэ бүгдийг цэгцлэх гээд Улаанбаатар хот ингээд 2040 оны төлөвлөгөө оруулж ирж байна гэж ойлгож байна. Одоо ингээд бид нар байгаа дэд бүсдээ шавагдсаар байгаад ингээд өнөөдөр ямар ч төлөвлөлтгүй, төлөвлөгөөгүй, зохион байгуулалтгүй, стандартгүй ийм жишээг Улаанбаатар хотоос харж болно л доо. Яг бодитойгоор. Өнөөдөр би дахиад хэлье. Бүтэн биеийн тамирын талбайтай үлдсэн 1 ч сургууль, цэцэрлэг байхгүй. Энэ бүгдийг өгнө гэж Улаанбаатар хотын төлөвлөгөөнд байгаагүй. Тэгэхээр одоо энэ Улаанбаатар хотын энэ удирдлагуудад аягүй том маш том даалгавар үүсэж байгаа юм. Энийг яаж цэгцлэх вэ гэдэг. Шинээр юм хийх гэхээр өмнөх асуудлууд нь дандаа ингээд хүндэрдэг, тэгээд маш том ийм зохион байгуулалтгүй болгочихсон. Тэгээд энэ дээр Улаанбаатар хотын удирдлагууд маань ямар бодолтой байгаа юм бэ? Мэдээж энэ төлөвлөгөөг хэдүүлээ сайхан батлаад явъя.

Гэхдээ 2002 оны тэр дүгнэлт гэж байдаг юм уу, тэн дээр ямар дүгнэлттэй байдаг юм бэ? Манай төрийн байгууллагын дүгнэлтүүд дандаа л 1 95-100 хувийн дүгнэлттэй гардаг юм. Улаанбаатар хотын авто зам гээд л тэгсэн чинь 95 хувийн дүгнэлттэй гээд л. Тэгтэл яг бодитойгоор бид нар олон улсын стандартын

шаардлага хангасан авто замаар явж өнөөдөр ажилдаа ирж байна уу гэдгээ бас бодох хэрэгтэй.

Тэгэхээр Нямбаатар даргад маш том даалгавар байна. Өнөөдөр дахиад хэлье Улаанбаатар хот төлөвлөлтгүй, төлөвлөгөөгүй, зохион байгуулалтгүй, замбараагүй, томоос том тосгон болж хувирсан. Энд дэд бүтцүүдээ тэлээд, зохион байгуулалтуудаа нэмээд, ингээд шинэ дэд бүтцүүдийг ингээд оруулж ирэх чинь сайшаалтай байна. Тэгэхээр энэ дээр манай Их Хурлын гишүүд дэмжээд явах байх. Тэгээд энэ 2002 оны тэр дүгнэлтүүд гэж байдаг юм уу? Тэн дээр хариу.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Нямбаатар дарга хариулах уу? 6 номерын микрофон.

Х.Нямбаатар: Баярлалаа. Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Би Шижир гишүүний асуултад хариулах. Өмнөх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ өгсөн байгаа. Тухайлах юм бол, Монгол Улсын Их Хурал 2013 онд Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх, хүртэлх хөгжлийн чиг хандлагыг батлахдаа өмнөх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр 29.6 хувьтай хэрэгжсэн гэсэн ийм дүгнэлт гарсан. Ийнхүү энэхүү ерөнхий төлөвлөгөө хэрэгжээгүй шалтгаан нь суурьшилт тэлэлтийн бүсийн хүрээ хязгаараа тогтоож чадаагүй, дагуул хотуудын хөгжлийн удаашралтай, нийгмийн дэд бүтцийн тэнцвэргүй байдал, авто замын, зам тээврийн сүлжээний хүртээмжгүй байдал, инженерийн дэд бүтцийн хязгаарлагдмал байдал зэрэг эдгээр зүйлсээс болж энэ төлөвлөгөө хэрэгжихэд хүндрэл учирсан.

Үүнээс гадна эдгээр төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамгийн их тулгамдсан асуудал бол хөрөнгө, санхүүгийн хүртээмжгүй байдал байсан. Дээр нь төрийн байгууллагуудын уялдаагүй шийдвэр гаргасан, 4 дүгээрт албан тушаалтнуудын эрх хэмжээгээ хэтрүүлэн газар олголтыг олгосон зэрэг эдгээр зүйлсээс шалтгаалж энэхүү ерөнхий төлөвлөгөө хэрэгжээгүй гэдэг дүгнэлтэд хүрсэн.

Өөрөөр хэлбэл, 1984 оноос хойш Улаанбаатар хотод 1 ч ширхэг ДЦС өнөөдрийг хүртэл хугацаанд нэмж баригдаагүй. Одоо ингээд 41 жил болж байна. Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг одоо ингээд ашиглалтад орж байгаа гэж үзвэл энэ зөвхөн цахилгаан станц Улаанбаатарын орчимд байгуулагдаж байгаа. Дулааны станцын хувьд Амгалангийн дулааны станцыг барьж байгуулсан. Өөрөөр дулаан, цахилгааны хангамжийг нэмэгдүүлэх, эх үүсвэр нэмэгдүүлэх чиглэлээр огт хөрөнгө, мөнгө тавьж төлөвлөлттэй ажил хийгдээгүйгээр шалтгаалж, Улаанбаатар хотын дулаан хангамжийн боломжит байршууд буюу 1м2-ыг нь 506 төгрөгөөр халаадаг тэр дулааны сүлжээ хожсон байршууд дээр замбараагүй газар олголт хийж, өнөөдрийн энэ хот төлөвлөлтийн замбараагүй байдал үүссэн гэдэг ийм дүгнэлтэд хүрсэн. Ингээд бид энэ 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөөр хамгийн түрүүн тэргүүн ээлжид Улаанбаатар хотын тэлэлт, суурьшлын бүсийг тодорхойльё. Түүндээ тохирсон инженер хангамжийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлье. Би ганцхан жишээ хэлье. Улаанбаатар хот өнөөдөр нийт Монгол Улсын эрчим хүчний хэрэглээний 59.6 хувийг хэрэглэж байгаа эрчим хүч.

Тэгвэл 2035 он гэхэд яг өнөөгийнхөө хурдцаар өсөхөд Улаанбаатар хотын цахилгаан хангамжийн хэрэглээ 1000 мвт-ын-2000 мвт-ын-аар руу тэлэхээр ийм техникийн нөхцөл үүсчхээд байгаа юм. 2000 мвт-ын-аар нэмэгдэх буюу нийтдээ

3000 мвт-ын эрчим хүчний хэрэглээтэй болох тохиолдолд Улаанбаатар хотын дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөн шинэчлэхэд яг өнөөдрийн гарсан тооцоогоор 2 тэрбум ам.долларын эх үүсвэр шаардагдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл, би энд зөвхөн ДЦС-уудыг барих зардлыг тооцдоггүйгээр ийм дулаан, цахилгааны хангамжийн эх үүсвэр нэмэгдсэн тохиолдолд тухайн цахилгааны дамжуулах, түгээх шугамыг өргөтгөн шинэчлэхэд 2 тэрбум ам.долларын ийм зардал гарч байгаа.

Тэгэхээр цаашид бид нар өмнөх ерөнхий төлөвлөгөөний гол алдаа нэгдүгээрт хөрөнгөгүй байж, хоёрдугаарт эх үүсвэрүүдээ барьж чадаагүйгээс шалтгаалаад замбараагүй суурьшлууд бий болсон. Тэгэхээр бид нар цаашид бидний хамгийн түрүү ээлжид 40 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээ.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Шижир гишүүн нэмэлт асуулт асууя.

Ө.Шижир: Тэр 5 дахь удаагийн 2002 оны ерөнхий төлөвлөгөө 29 хувь гээд та хэлж байна. Тэгээд үүний гол шалтгаан нь тухайн үеийн Улаанбаатар хотын газрын алба болон Ерөнхий архитекторын энэ хүмүүс эрх мэдлээ хэтрүүлснээс шалтгааллаа гээд дүгнэж байна шүү дээ.

Тэгэхээр энэ тухайн үед энэ Газрын албаны даргаар ажиллаж байсан, Улаанбаатар хотын Ерөнхий архитекторт ажиллаж байсан энэ хүмүүст хариуцлага тооцсон юм байдаг юм уу? Энэ хүмүүс жишээ нь 3000 орон сууц барьж байхад 1 ч хүүхдийн сургууль, цэцэрлэг байхгүй, түргэний тэрэг орох, гарах гарц байхгүй, галын команд орох, гарах гарц байхгүй ийм архитектур ийм төлөвлөлтүүдийг хийсэн энэ хүмүүст ямар нэгэн хариуцлага тооцсон тохиолдол байна уу? Улаанбаатар хотын зүгээс өгсөн гомдол байна уу? Тэгэхгүй бол энэ чинь яаж байна вэ гэхээр нийт Улаанбаатар хотын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах Үндсэн хуулийн юмыг нь хуулиар зөрчихөж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн байдлаар арга хэмжээ авах нь зүй ёсны байх. Тэгэхээр хотын дарга энэ дээр арга хэмжээ авсан, хуулийн байгууллагад өгсөн ийм юмнууд байгаа юу?

Ж.Бат-Эрдэнэ: Нямбаатар дарга, 6 номер.

Х.Нямбаатар: Улаанбаатар хотын захиргааны зүгээс өмнөх үеийн удирдлагуудаас хууль хяналтын байгууллагуудад хандаж шалгуулахаар бичиг өгүүлж явсан асуудлыг би сайн хэлж мэдэхгүй байна.

Миний бие бол Нийслэлийн газрын албаны дарга бөгөөд Ерөнхий архитектураар ажиллаж байсан Цэлмэгтэй холбоотой гомдол, мэдээллийг хууль хяналтын байгууллагуудад гаргасан. Эрүүгийн хэрэг үүсгээд шалгах ийм ажиллагаа явагдаж байгаа гэдэг ийм товчхон мэдээлэлтэй байна.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүн маш том баг ажиллаж байгаа л даа. Энэ 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, энэ ажлын хэсэг дээр 2020 Улаанбаатар хотыг хөгжүүлэх, 2030 Улаанбаатар хотыг хөгжүүлэх 30 дээр суусан ийм улсууд байгаа юу энэ ажлын баг дээр? Дандаа цоо шинэ баг, хүн, мэргэжилтнүүд ажилласан уу? Энийг нэгд асууя.

Хоёрт, энэ яамнуудтай хэр уялдаж ажилласан бэ? Одоо энэ 2040 он хүртэл хөгжүүлэх Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр энэ одоогийн хотын даргын ажил биш шүү дээ. Энэ бүхэл бүтэн энэ Засгийн газар, энэ 20 орчим яамнууд чинь хамаарахгүй яам гэж би 1 ч байхгүй гэж ойлгож байгаа. Тэгээд ингээд Нямбаатар гэдэг хүний ажил юм шиг Засгийн газрын сайд нараас нь 1 ч байхгүй, Барилга, хот байгуулалтын яамны сайд, Эрчим хүчний сайд, Дулааны сайд асуудал хариуцсан энэ сайд нар бүгд байх ёстой шүү дээ. Тэгээд бүгд ингээд мэдээллүүд нь хэр уялдаатай ингэж боловсродж орж ирж байгаа юм? Дараа нь ингээд асуудал ярихаар бүгд мэддэггүй. Энэний цаана дандаа төсөв хөрөнгө яригдаж байгаа. Сангийн яам Сангийн сайд чинь мэдэж байгаа юу? Энд шаардлагатай эх үүсвэрийг Улаанбаатар хот ганцаараа гаргах юм уу? Яагаад ч чадахгүй шүү дээ. Улсын төсөв ганцаараа чадахгүй гээд. Тийм учраас юу гэж асуух гэж байна гэхээр энэ холбогдох энэ яамдын уялдаа холбоог яаж хангасан юм бэ гэж. Хоёрт.

Гуравд, энэ хөгжлийн төлөвлөгөөтэй холбогдуулж энэ сая бас Шижир гишүүний асуулт дээр бас дурдагдаж байгаатай холбогдуулж ямар хууль, эрх зүйн орчнуудад өөрчлөлт хийх гэж байгаа вэ дагаж? Тухайлбал 2020 чинь гэхэд 29-хөн хувьтай гээд бид нарыг Нийслэл дээр байхад ярьдаг байсан. Одоо 30 чинь хэдэн хувьтай явж байгаа юм? 30 чинь өнөөдрийн байдлаар? Одоо бид нар дараа нь 30-ийгаа гаргаагүй байж байтал 40-ийгөө батлах гээд ингээд сууж байна.

Тэгээд энэ чинь ерөөсөө таны сая ерөнхий төлөвлөгөө 2020 29-хөн хувьтай байгаагийн нэг шалтгаан нь замбараагүй газар олголт гэж байна шүү дээ. Олон шалтаг шалтгаанууд байгаа байх. Тэрний нэг нь замбараагүй газар олголт мөн үү мөн. Тэгээд энэ Улаанбаатар хот дотор чинь өнөөдөр цахилгаан дамжуулах агаарын шугам аж ахуйн нэгж, айл өрхийн дундуур л явж байгаа шүү дээ. Хязгаарлалтын бүс гэж байдаг. Төмөр зам хязгаарлалтын бүс гэж байдаг. Энэ бүх хязгаарлалтын бүсүүдийг зөрчөөд газар олголтуудыг үнэхээр замбараагүй олгосон шүү дээ. Тэгэхээр энэ холбогдох дагаж энэ олон хуулиуд дээр хязгаарлалтын, хориглолтын ийм заалтуудыг оруулж ингэж байж цаашдаа энэ газар олголтын асуудлыг явуулахгүй бол өнөөдрийнх шиг ийм сүл байгаад байгаа бол цаашдаа яг энэ байдал ар.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Нямбаатар дарга, 6 дугаар микрофон.

Х.Нямбаатар: Сандаг-Очир гишүүний асуултад би товчхондоо хариулт өгье. 2030 он хүртэлх чиг, хандлага гэсэн ийм томьёоллоор орж ирсэн. Өөрөөр хэлбэл, манай ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт 2020 оноор дуусгавар болсон. Бидний хөндлөнгийн аудит хийлгэсэн хэрэгжилтийн үнэлгээ хийлгэсэн явдал бол 2020 он хүртэлх ерөнхий төлөвлөгөө. Тэр дундаа 2013 онд дахиж 2020 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөгөө тодотгосонтой холбоотой тэр дүгнэлтүүд дээр бид нар дүн шинжилгээ хийлгэсэн. 30 он хүртэлх дүгнэлт гарахгүй энэ бол 30 он хүртэл хөгжүүлэх чиг хандлага гэсэн ийм бодлогын баримт бичиг байдлаар батлагдсан.

Хоёр дахь асуулт, энэ 13 оны тодотгол дээр суусан багаараа ажиллаж байна уу, эс үгүй бол шинэ баг ажиллуулсан уу гээд. Яг 13 оны тэр тодотгол дээр суусан баг ажиллаж байгаа. Тэр дундаа энэ удаагийн ерөнхий төлөвлөгөө нэг онцлогтой. Өмнөх 4 ерөнхий төлөвлөгөөг тухайн үеийн ЗХУ-ын зураг төслийн хүрээлэнгүүд хийж өгсэн бол 5 дахь ерөнхий төлөвлөгөөг манай дотоодын хот байгуулагчид хийсэн. Тодотгол ч гэсэн мөн ялгаагүй. Тэгвэл энэ удаагийн 6 дахь ерөнхий төлөвлөгөөг Нийслэл Улаанбаатар хотын дэргэд байдаг Зураг төслийн

хүрээлэн орон нутгийн өмчтэй аж ахуйн тооцоот байгууллага өөрөө дагнаж, голлож энэ 2017 оноос хойш энэ 8 жилийн хугацаанд энэ 40 он хүртэлх өрөнхий төлөвлөгөө дээр суусан.

Ерөнхий төлөвлөгөө гэдэг талаасаа тухайн хот, суурин газрын суурьшилт, тэлэлтийн бүсийг тодорхойлохоос гадна хүн ам зүйн бодлого, эдийн засгийн өсөлт, дэд бүтцийн хөгжил, нийтийн тээврийн хөгжлийг бүхэлд нь тодорхойлсон ийм цогц баримт бичиг байдаг. Энэ утгаараа өнөөдрийн энэ бодлогын баримт бичиг дээр нийтдээ Монгол Улсын Засгийн газрын харьяа 14 яамны төлөөллүүд оролцож ажилласан. 12000 гаруй иргэдээс бичгээр саналуудыг авсан байгаа. Тэр дундаа саяын таны хэлж байгаа Сангийн яам болон Эдийн засгийн хөгжлийн яамтай бид нар нэлээн бас Засгийн газрын хуралдаан дээр энэ 2021 онд анх ороод тэгээд буцсан юм.

Тэгээд энэнээс хойш дахиж ажиллаад тэгээд нийтдээ 242 их наяд төгрөгийн төсөвт өртгөөр 2040 он хүртэл өрөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлнэ гэж үзсэн. Үүнийхээ 120 гаруй тэрбум төгрөг, их наядыг улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр явъя. Үлдсэн хөрөнгийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр гадаадын зээл, тусламжаар явъя гэдэг ийм төлөвлөлтийг оруулж ирж, Сангийн яам саналаа өгч, Улсын Их Хуралд сая өргөн мэдүүлэх энэ зөвшөөрлийг өгсөн байгаа гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн тодруулна.

Х.Нямбаатар: Энэ Нямбаа даргаа энэ хотын хөгжлийн төлөвлөгөө, өрөнхий 40 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөг энэ Их хурлаар ер нь оруулж ирж батлах нь аль хуулиараа явж байгаа юм? Энэ Их Хурал ер нь ингэж баталж өгөх нь зөв юм уу? Одоо хар л даа ингээд ийм зузаан ийм З дэвтэр ном хэдэн ч хуудастай юм. Энэ олон энэ дээр маш олон хоног олон хүмүүсийн хүч хөдөлмөр шингэсэн, дандаа мэргэжлийн улсууд юм. Энэ парламентын 126 чинь хот төлөвлөгч, инженерийн чиглэлээр маш цөөхөн хүн байгаа шүү дээ. Манай Лувсанжамц гишүүнээс бусад нь ер нь бараг өөр мэргэжлийн улсууд байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ улсууд чинь ингээд энэ хотын өрөнхий төлөвлөгөөг батлахад ер нь хэр зохистой юм? Улаанбаатар хот өөрөө ер нь цаашдаа ингээд хөгжлийн өрөнхий төлөвлөгөөгөө батлаад, өөрөө удирдах ёсны байгууллагатай, Иргэдийн хурлаараа батлуулаад ингээд төсөв, санхүүгийн асуудлыг л Их Хурал, Засгийн газартай ярих асуудлыг л ярьдаг баймаар юм шиг санагдах юм. Надад энэ Их Хурал батлаад ингээд.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Хот байгуулалтын тухай хуульд Улаанбаатар хотын хөгжлийн өрөнхий төлөвлөгөөг Монгол Улсын Их Хурлаар батлуулахаар ингээд хуульчлагдсан байгаа. Тэгээд энэ дагуу оруулж ирж байгаа. Түрүүн Сандаг-Очир нэг гишүүний асуултад би бас дутуу хариулчихлаа. Ямархуу хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулахаар бас энэ өрөнхий төлөвлөгөөний араас явж байгаа вэ гэхээр нэгдүгээрт Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Хот байгуулалтын тухай хууль, Улаанбаатар хотын, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Тээврийн тухай хууль гээд олон хууль тогтоомжуудад өөрчлөлт орохоор байгаа. Тухайлах юм бол масс тээврийн хэрэгслийг бид нийтийн тээврийн нэг төрөл хэлбэр болгоход замын хөдөлгөөний

аюулгүй байдлын дүрэм, журам, түүнтэй холбоотой хууль тогтоомжуудад хүртэл өөрчлөлт оруулахаар байгаа.

Миний бие Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар томилогдоноос хойш 1 жил 2 сар гаран болж байна, 3 сар болох гэж байна. Энэ хугацаанд нийт.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Нямбаатар даргын микрофоныг, 6 номерын микрофон гүйцээгээд хариульяа.

Х.Нямбаатар: Тийм. Энэ өнгөрсөн 1 жил гарангын хугацаанд Монгол Улсын Засгийн газраас санаачилж, Нийслэл дээр бас ажиллаж байсан хуулийн баг, бүрэлдэхүүн боловсруулалтыг нь хийж, Улсын Их Хурлаар 60 гаруй хууль тогтоомжийг, анхдагч хуулийн төслүүд болон хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдийг батлуулсан.

Одоо Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцэхээр бэлдээд байгаа 11 хуулийн төсөл байгаа. 2040 батлагдсаны дараа ажлын хэсгээс ямархуу санал, дүгнэлт гарах вэ? Саяын дурдсан бодлогын баримт бичгүүд болон хууль тогтоомжуудад бас давхар өөрчлөлтүүд орохоор ийм бэлтгэл ажлуудыг давхар хангаж ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Ер нь сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын хүн ам жилээс жилд хүчтэй, эрчимтэй нэмэгдэж байгаагийн үр дүнд Улаанбаатар хотод нийгэм, эдийн засгийн цогцолбор эдийн засгийн 66 орчим хувь нь үйлдвэрлэгдэж байгаа энэ хотод хууль, эрх зүйн орчныг шинэчлэх ийм шаардлагууд цаг үетэйгээ шаардаж бий болж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Батбаатар гишүүн яах юм сайдыг нь орж ирэхээр асуух юм уу? Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Улаанбаатар хотын хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө 2040-ийг зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Энэ бас батлагдах цаг хугацаанаасаа хоцрогдолтой ингээд явж байгаа. Үүний цаана бас гол концепцуудыг бас тодруулж иргэд олон нийтэд хэлээч гэж би хүсэж байгаа юм. Ер нь хот төлөвлөлтийн асуудлыг бид байшин барилга барих гэдэг юм уу ийм зүйлээр бас жоохон төсөөлөлтэй олон нийт бас хандаад байдаг. Уг нь үүний цаана иргэдийн оролцоотой, шинжлэх ухааны үндэстэй, ингээд хувийн хэвшлийн оролцоог дэмжсэн, хүний эрхийг хангасан тухай л байгаа. Өнөөдөр баахан орон сууцны хороолол барьчхаад дунд нь сургууль, цэцэрлэг барьж чадахгүй, ногоон байгууламж барьж чадахгүй байна гэдэг цаана нь хүний эрх буюу ерөөсөө л хүүхдүүдийн сурч боловсрох эрх, тэгээд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх л зөрчигдэж байгаа юм.

Тэгэхээр энэ өнцгөөсөө хүний эрхийг хангах хот болгох, энэ хүний эрхийг хангах хотын гол хэмжүүр бол энэ хүүхдийн эрхээр хангагддагаар л, хүүхдийн эрхийг хэрхэн яаж хангаж байгаагаар л шийднэ. Тэгэхээр энд чиглэл үзэл баримтлал буюу хүнд зориулж энэ хотыг хийх чиглэлдээ энэ бичиг баримт орж ирж байгаа байх гэж би бодож байгаа. Тэгээд энэ чиглэлээс нь би бас хэд хэдэн асуудлыг тодруулж бас олон нийтэд хэлээсэй гэж бодож байгаа юм.

Ер нь Улаанбаатар хотод 2040 он гэхэд үе шаттайгаар явахад хэдэн хүн амтай болох вэ? Ер нь цаашдаа тогтвортой хөгжлийн асуудал дээр усан хангамжийн асуудал хамгийн чухал байгаа. Ер нь усны асуудлаа шийдсэн газар л хот байгуулдаг. Нэг бол усны эх үүсвэрийн хажууд барина, нэг бол энэ асуудлаа маш ухаалгаар шийдсэн газар л хотыг байгуулж байгаа. Тэгэхээр бид нар бас цаашдаа энэ Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангахын тулд гүний усыг хэрэглээд байх биш, гадаргын усыг ундны болон бусад зориулалтаар ашиглах асуудал дээр ямар бодлогын өөрчлөлтүүд орж ирэх гэж байгаа вэ? Энэ ус гэдэг бол нэг талдаа баялаг байгаад байгаа. Бид ингээд үерийн асуудал болохоор халаглаад л байгаа боловч уг нь энийгээ хуримтлуулаад, тогтоогоод авбал маш том боломжууд байдаг.

Дээрээс нь Улаанбаатар хот маань 4 голын ай савд байгаа учраас маш том үерийн эрсдэл дээр байж байгаа. Тэгэхээр энэ үерийн эрсдэлийг голын эхэн дээр л барихаас өөр арга байхгүй байхгүй. Тэгэхээр цаашдаа энэ одоо гадаргын усны менежмент дээр Туулын усан цогцолбор гэдэг юм уу, эргээд энэ Сэлбэ дээр ямар төлөвлөлтүүд байгаа энэ талаар бас мэдээллүүд өгөөч? Би Сэлбийн эхэн дээр баригдсан хиймэл нуур байгаа л даа жижигхэн нуур. Энийг бариад 2 жил дотор ус нь дүүрнэ гэсэн чинь нэгхэн зуны, нэгхэн удаагийн борооны усаар дүүрсэн. Хэрэвзээ тэр нуурыг барьж аваагүй байсан бол 2 жилийн өмнөх болсон үерээр Улаанбаатар хотод орж ирэх усны түвшин 1-2 метрээр нэмэгдэх байсан. Жижигхэн Сэлбэ гол ингэж эфект үзүүлэхээр байсан.

Туул голын далан жишээ нь аж ахуйн аргаар барьсан далан байгаа. 1960-аад оны үед. Тэгээд энэ асуудлаасаа Хэнтийн нуруунд хур тунадас их ороход шууд Улаанбаатарт нөлөөлнө. Энэ Улаанбаатарт чинь 2 сая гаруй хүн байна, маш их хэмжээний өмч хөрөнгүүд байна. Тэгэхээр энэ цаана өмч.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 6 номерын микрофон.

Х.Нямбаатар: Би Сайнзориг гишүүний асуултад хариулья.

Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний урьдчилсан төсөөллөөр Улаанбаатар хотын хүн амыг 2040 он гэхэд 2 сая 100 мянган хүн амтай байхаар төлөвлөж байгаа.

Хүртээмжтэй хот гэдэг талаар та асуулаа сая. Тэгэхээр 2040-ийн маань сая нэлээн цаг хугацаа оройтож өргөн барьсан асуудал өнгөрсөн жил батлагдсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд орсон өөрчлөлтийн хүрээнд Улаанбаатар хотыг 14 хотуудын нэгдэл, 42 нэгж хороололтой болгох энэ хүрээнд бид нар 2040 дээр тодорхой өөрчлөлтүүд орсон. Өөрөөр хэлбэл, 14 хот маань тус бүрдээ 20 минутын хот байх, хүртээмжтэй хот байх, хүндээ ээлтэй байх, эрүүл мэнд, боловсрол, соёлын хүртээмжийг 20 минут тутамд авах ийм байдлаар төлөвлөлтийг хийсэн. Өмнөх ерөнхий төлөвлөгөөнүүд дээр гарсан хамгийн том алдаа юу байсан бэ гэвэл тэр хөрөнгө мөнгөгүй дэд бүтцийн хязгаарлагдмал нөхцөл байдалтай байснаас гадна хорооллууддаа буюу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүдээ огт батлуулаагүй, зуруулаагүй байсан.

Тэгэхээр бид нар энэ 2040-ийн араас гаднын зураг төслийн томоохон компаниудын дунд нээлттэй тендер зарлаж, Улаанбаатар хотын 14 хот, 42 нэгж

хороолол, харьяа дагуул хотуудынхаа хэсэгчилсэн өрөнхий төлөвлөгөөнүүдийг зуруулахаар тендер зарлаж байгаа гэдгийг хэлье.

Сүүлийн үед Улаанбаатар хот дам үерийн нөлөөлөлд өртдөг болсон. Өөрөөр хэлбэл, Хэнтийн нуруунд орсон хэдэн өдрийн хүчтэй нурууны улмаас Хэнтий нуруунаас эх авч урсаж байгаа Туул голын сав газар бүхэлдээ үерт өртдөг болсон. 1987 онд ЗХУ-ын эрдэм шинжилгээний байгууллага Туул усан сан цогцолбор гэдэг гадаргын усан сангийн төслийн ТЭЗҮ-ийг боловсруулсан юм байна лээ. Тэгээд энийг манай бас Ус сувгийн газар энэ тэр очиж энэ ТЭЗҮ-ийг авсан байгаа.

Тэгэхээр энэ Туул усан сан цогцолборыг бид нар нэг бол Дэлхийн банк тэргүүтэй томоохон донор байгууллагуудтай хамтарч ажиллах, эс үгүй бол хувийн хэвшлээр хийлгэх гэдэг ийм 2 хувилбартай байгаа. Хувийн хэвшлээр хийлгэсэн тохиолдолд Улаанбаатар хотын нийт усан хангамжийн 25 хувийг гадаргын усаар хангах, 30 орчим хувийг бид нар цэвэршүүлсэн усан сан буюу энэ СХД-ийн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа төслийн хүрээнд шийдэх, 3 дахь эх үүсвэр бол гүний ус гэсэн ийм хувилбараар усан хангамжийнхаа эх үүсвэрийг шийдэхээр ингээд төлөвлөсөн гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Сайнзориг гишүүн тодруулна.

П.Сайнзориг: Тэгээд би энэ их чухал бичиг баримт учраас илүү мэдээлэл байгаасай л гэж бодож байгаа юм. Бид хог хаягдал гэхээр хог хаягдал дээр зардал гаргаж хог хаягдлаа шийддэг байсан. Ер нь цаашдаа энэ хот, суурин газруудын хог хаягдлыг мөнгө болгох ямар бодлогын асуудлууд орж ирж байгаа вэ? Энэ дээр бас хотын удирдлагуудаас бас хэлж өгөөч гэж хүсэж байгаа юм.

Дээрээс нь яах вэ энэ бүс нутгийн нөлөөлөл гэж бий. Улаанбаатар хотыг бас бодоогүйгээр энэ байршлыг ер нь сонгоогүй юм байна лээ. Анхнаасаа л энэ бас олон цэгийн уулзвар байсан. Энэ ч тэлэлттэй явж байна. Тэгэхээр энэ бүс нутгийн нөлөөлөл дээр Улаанбаатар хотын цаашдын хөгжил хэрхэн яаж нөлөөлөх вэ? Төв аймагтаа хэрхэн яаж нөлөөлөх вэ? Тээвэр ложистикийн асуудал дээр энэ зэргэлдээ оршиж байгаа аймгуудтайгаа хэрхэн, яаж хамтдаа хөгжих вэ гэдэг асуудал дээр ямар концепцын зүйл орж байгаа вэ гэдэг зүйлийг бас бас тодорхой хэлээч.

Тэгээд энэ бичиг баримтыг өрөнхийдөө дотоодын эрдэмтдээс гадна, ямар гаднын экспертууд.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 6 номерын микрофон Нямбаатар дарга хариулья.

Х.Нямбаатар: Бид нар олон улсын нээлттэй тендер зарлаад Сөүл хотын Декон гэдэг зураг төслийн хүрээлэн энэ манай 2040 дээр зөвлөгөө өгч ажилласан байгаа. Бид тайлангуудаа бүрэн хүлээж авсан.

Сайнзориг гишүүний түрүүчийн ярьж байсан юм дутуу би бас хариулчхаж. Энэ Сэлбэ голын эхэн дээр бид нар 1 хиймэл нуурыг хувийн секторын хөрөнгө оруулалтаар хийсэн. Тэгвэл энэ жил бид нар 5 ийм хөв цөөрмийг Сэлбэ голын дээд эхэн дээр Нийслэлийн Геодези, зураг төслийн Геодези, усны барилга байгууламжийн алба барьж байгуулахаар ажлын зураг батлагдаад одоо энэ хавар ажил нь эхлэх гэж байгаа.

Өөрөөр хэлбэл, бид нар хойд талаасаа эхлэлтэй үерийн усны тохиуулгууд хийх ийм боломж бүрдэж байгаа гэдгийг хэлье. Өнөөдөр хог хаягдлыг 98 хувьтай бид нар дарж булшилж байгаа. Тэгвэл та бид бүгдийг энэ 2040-ийг хэлэлцэж байх энэ үед Нийслэл дээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн жагсаалт гараад Улаанбаат.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 6 номерын микроныг нээе.

Х.Нямбаатар: 34мвт-ын-ын хог шатаах үйлдвэрийн төр, хувийн хэвшлийн түншлэлийн сонгон шалгаруулалтыг хийх ажил яг ид явж байгаа. Тэгээд бид нарын эхний төлөвлөгөөгөөр Морингийн даваанд 34мвт-ын хог шатаах ийм үйлдвэрийг барьж байгуулах гэрээ хэлцэл энэ хавартаа багтаж дуусна.

Ингээд бид ингэсэн тохиолдолд цаашид дарж булшлах технологиос 100 хувь шатаах технологи руу шилжиж байгаа. Эрчим хүчээ өнөөдөр Диспетчерийн үндэсний төвтэй бид нар урьдчилсан байдлаар Pi Pi Эй гэрээнийхээ анхны үнийн саналыг солилцоод сая орж ирсэн гэдгийг хэлье. Өөр юу асуусан билээ? Болчихлоо.

Ж.Бат-Эрдэнэ: Алдаржавхлан гишүүн асуулт асууна.

Ж.Алдаржавхлан: 2 асуулт байгаа юм.

Нэгдүгээрт, Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ер нь урьд өмнө хэдэн удаа энэ Их Хурлаар баталж байсан юм бэ? Энэ удаагийн өргөн барьсан нь өмнө урьд өмнөхөөсөө юугаараа ялгаатай юм гээд энийг нэгд хариулж өгөө гэж.

Хоёрт нь Байнгын хорооны даргаас ба асуулт байна. Одоо энэ 2040-ийн ажлын хэсэг гэж байгуулагдана. Одоо Төрийн байгуулалтын байнгын хороонд байгаа гишүүдээсээ та бүрдүүлж байгуулах гээд байна уу, эс үгүй бол Их Хурлын түвшинд байгуулах юм уу? Энийгээ бас ингээд хариулж өгөөч. Ийм 2 л асуулт байна.

Ж.Алдаржавхлан: Би эхлээд хариулчих уу? Ажлын хэсэг байгуулагдана. Ажлын хэсэг Төрийн байгуулалтын байнгын хорооноосоо байгуулна гэсэн ийм зарчим барина л гэсэн бодолтой байж байгаа.

6 номерын микрофон Нямбаатар дарга хариулья.

Х.Нямбаатар: Энэ өмнөх 5 ерөнхий төлөвлөгөөний 1 ерөнхий төлөвлөгөөг л Улсын Их Хурлаар батлуулсан юм байна лээ. 2013 онд нөгөө 20 он хүртэл тодотгол, 30 он хүртэлх чиг хандлагыг. Яагаад ингэсэн гэхээр Хот байгуулалтын тухай хууль дээр Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг 5.1.5-д нь Улсын Их Хурал батална гэсэн ийм зохицуулалттай юм байна лээ.

2002 оны ерөнхий төлөвлөгөөг Засгийн газраар батлуулсан гэж ийм манай судалгааны багийнхан үзсэн. Өмнө нь мэдээж хэрэг өөр тэр өмнөх 4 ерөнхий төлөвлөгөөг өмнө нь хууль тогтоох байгууллагаар баталсан ийм түүх байхгүй юм байна лээ.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Ялгаа, энэ удаагийн ерөнхий төлөвлөгөөний ялгаа?

Х.Нямбаатар: Энэ удаагийн ерөнхий төлөвлөгөөний нэг онцлог бол хүртээмжтэй хот байя гээд өнгөрсөн жил та бидний хамтдаа батлуулсан 14 хотуудаас Улаанбаатар хотын үндсэн суурьшил бүрдэхээр байгаа. Мөн өнгөрсөн жилийн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд заасан хаяа дагуул хотуудын эрх зүйн байдалтай уялдаж энэ ерөнхий төлөвлөгөө боловсрогдсон.

Хамгийн гол үндсэн асуудал бид нар энэ хотын ерөнхий төлөвлөгөө хэрэгжсэнээр Улаанбаатар хотын өмнөх бүх ерөнхий төлөвлөгөөнүүдийн хэрэгжилт хангагдаагүй энэ алдааг засах, ингэхийн тулд инженер хангамжийнхаа тэр хүртээмжийг нэмэгдүүлэх замаар төр, хувийн хэвшлийн оролцоотой энэ ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлье гэсэн ийм зорилгыг дэвшүүлж орж ирсэн.

Ж.Бат-Эрдэнэ: Нэмэлт үү тодруулах уу? Алдаржавхлан гишүүн тодруулъя.

Ж.Алдаржавхлан: Байнгын хорооны дарга тэгвэл хэдүүлээ энэ Төрийн байгуулалтын байнгын хорооноос ажлын хэсгээ байгуулах юм бол та энэ Нийслэлээс сонгогдсон энэ хэдэн гишүүдийг бас оруулж өгөөч гэж хүсэж байгаа юм. Өөр Байнгын хороонд байгаа ч гэсэн. Тэгээд бас Нийслэлд байсан олон хүмүүсийг оролцуулж, юуг нь сонсоосой гэж хүсэж байна.

Яагаад гэхлээр бид нар зовлон дундуур нь туулчихсан учраас бас илүүг сайн ойлгох байх гэж бодож байгаа шүү. Тэгээд Байнгын хорооны даргад ийм хүсэлт байна. Бас боломж байвал хариулж өгөөч гэж хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ямар ч л байсан хүсэлтүүдээ бас гаргачих тэгээд бодолцъё. Ямар ч л байсан мэдээж Улаанбаатар хотоос сонгогдсон хоттойгоо бас ажил, амьдрал холбоотой туршлага бүхий гишүүдээс орох нь зүйтэй байх гэж бодож байгаа юм. Тийм, дэмжиж байна дэмжиж байна.

Би ас хэдэн асуулт асууя. Сая хэд хэдэн гишүүд бас хэлээд байх шиг байна. Энэ хот байгуулалтын хуульд яагаад орсон юм бэ, яагаад энэ Улсын Их Хурлаар энэ төлөвлөгөөг, ерөнхий төлөвлөгөө баталдаг юм бэ гээд. Энэ 2011 он шиг санагдаж байна. Та бүхэн бас тодруулж надаа хэлээрэй. Би сайн он сарыг нь сайн мэдэхгүй байна шүү. Зам, тээвэр, Барилга, хот байгуулалтын яамнаас энэ саналыг оруулаад энэ төлөвлөлт өөрөө хууль байх ёстой гэж оруулсан юм. Сая Нямбаатар дарга хэллээ шүү дээ. Нэг том алдаа бол энэ төлөвлөлтийн том алдаа бол тухайн удирдлага нь энэ өөрчлөлтөө хийгээд өрөөсөө тэр газар олголтуудыг замбараагүй олгосноос болж энэ хот төлөвлөлт бол алдагдсан гэж ярьж байгаа шүү дээ. Энэ бол бодит кэйс, бодит алдаа.

Тэгэхээр энийг ирсэн Засаг дарга, архитектур нь өөрсдийнхөө саналаар өөрчлөөд байдаггүй, хууль болгохын тулд Зам, тээвэр, Барилга, хот байгуулалтын яамнаас 11 онд байх санагдаж байна хууль болгож баталья гэсэн ийм саналыг оруулж ирж байж энэ 2030 оных чинь бол батлагдаж байсан шүү дээ. Хамгийн анхных нь юм. Одоо энэ 2 дахь нь орж ирж байгаа. Сая бас хэллээ шүү дээ энэ алдаа, дутагдал гээд байгаа юм.

Тийм болохоор хуульд миний 1 дүгээр асуулт бол хууль болсноос хойш хуульд өөрчлөлт оруулаад засаж залруулаад, ингээд тийм алдаа дутагдал

гаргаад, газар олголт гаргаад ингээд явсан ийм зүйлүүд байгаа. Тэд нарт хариуцлага тооцсон юм байдаг юм уу, үгүй юу гэж бас юм түрүүн асууна лээ. Би бас ийм асуудлыг л асуумаар байна. Хуульд өөрчлөлт оруулаад байна шүү дээ энэ чинь. Уг нь бол өөрчлөлт оруулахгүйн тулд хууль болгоод байгаа юм. Тэгээд л Улсын Их Хурал батлаад байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт нөгөө том том асуудлууд байна шүү дээ. Утаа, түгжрэл, эрчим хүчний дутагдал, энэ маань 2040 он гэхэд ер нь яачхав засагдах вэ? Яаж нөхөгдөх юм бэ? Ямар хөрөнгө оруулалт оруулах юм бэ? Сандаг-Очир гишүүн сая асуулаа шүү дээ. Энд нөгөө сайд нар чинь байх ёстой, Эрчим хүчний сайд байх ёстой, Барилга, хот байгуулалт, Зам, тээврийн сайд байх ёстой нөгөө давхар замын чинь асуудлууд, 2 түвшний замын чинь асуудлууд, хөнгөн галт тэрэг, өөр юу юу билээ тэр агаарын явдаг юмнууд чинь яах ёстой юм? Тээврийн чинь асуудал, зам тээврийн асуудал, түгжрэлийн асуудлууд яаж шийдэх юм, ямар хөрөнгө оруулалт оруулах юм, юу юу хийгдэх юм, нөгөө метро чинь хийгдэх бил үү, яах билээ? Энэ дээрээ энэ 3 асуулт утаатай холбоотой, түгжрэлтэй холбоотой, эрчим хүчтэй холбоотой тэгээд энэ хууль өөрчилж дураараа дургидаг ийм зүйлүүд байгаад байна уу, байхгүй байна уу? Эсвэл яг 2030 чинь өөрөө зөв зүйтэй яваад өнөөдөр хүрчхээд ирсэн үү гэдэг дээр ийм 4 асуултад хариулж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Ер нь хууль өөрчлөлтгүйгээр хууль зөрчөөд Улаанбаатар хотын урд хэсгийн Богд уулын бүх аманд газар олголтыг үе үеийн Байгаль орчны сайд нар олгочихсон. Одоо Богд уулын Улаанбаатар талын бүх амуунуудад хоосон газар огт байхгүй. Олголт хийхдээ дандаа аялал жуулчлалын отог нэрээр олголтууд хийгдсэн. Том том хаус, орон сууцын хорооллууд босчихсон. Богд Хан уулын ДЦГ-ын захирагааны тэр тогтоосон дэглэм, журмыг бүгдийг нь зөрчөөд олгочихсон. Наад талын хэсгүүд дээр нь бас хотын Засаг даргаар ажиллаж байсан хүмүүс зэрэгцүүлээд энэ Яармагийн дэнжийг бүхэлд нь олгоод дуусчихсан.

Би Нийслэлийн Засаг даргаар томилогдсоны дараа Газрын тухай хуульд өөрчлөлт оруулсан. Энэ нь Нийслэл Улаанбаатар хотод Нийслэлийн Засаг дараг 6 дүүргийн хэмжээнд газар олголт огт хийхгүй гэдэг Дүүргийн Засаг дарга нарын газар олгох эрх хэмжээг шууд хуулиар хориглосон.

Хоёрт нь Нийслэлийн Засаг дарга 4 тохиолдолд газар олгоно. Хуучин бол захирамж бичихдэг байсан. Нэгд нь, төрийн байгууллагад олгоё, хоёрт нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр олгоё, гуравд нь нөхөн олговоор олгоё, дөрөвт нь дуудлага худалдаагаар олгоё гэсэн ийм 4 олголтыг л үлдээсэн. Тэгэхээр одоо Бат-Эрдэнэ гишүүн, даргын хэлж байгаагаар хууль өөрчилж байгаад энэ замбараагүй олгосон уу гэвэл ерөөсөө бэлэн хууль байсаар байтал хууль дээгүүр гишгэж байгаад өнгөрсөн жилийг хүртэл олголт хийгдсэн. Энэ урд талын Богд уулын амны тэр хойно үлдсэн дэл сүл бүх газрууд дандаа аялал жуулчлалын отог.

Хоёр дахь асуултад би хариульяа. Давхар замын хувьд бид нар 1 дүгээр сарын 25 юм уу, 26-ны өдөр Туулын хурдны замыг барих тендерээ зарлаж байгаа. 6 сарын 1 гэхэд Улаанбаатар хотын 1 дүгээр тойрог замыг зарлаж байгаа. Бид нар энэ хурдны зам гэж ярих нь бас гаднынхан жоохон буруу ойлгоод байна лээ шүү. Энэ хот дотор хурдны зам гэж байдаггүй. Экспресс вэй/expressway/гэж нэрлэж байгаа. Тэгэхээр бид нар Туулын зам, тойрог 1 дүгээр зам гэдгээр ингээд нэрлээд явчихъяа гэж байгаа. Энэ 2 замыг бид нар хийх хугацааг 24-36 сарын хугацаанд

хийнэ. Эдгээр замууд хийгдсэнээр өнөөдрийн Улаанбаатар хотын авто замын түгжрэл 50 хувиар буурах боломжтой байгаа. Ийм учраас импортын замыг дахиж нэмж оруулж ирэхгүй байх үүднээс дугаарын дээд хязгаарыг тавьсан байгаа.

Цаашид Улаанбаатар хотын хурдны хязгаар нэмэгдээд ирэнгүүт импортынхоо машиныг оруулах тэр хязгаар дээрээ уян хатан өөрчлөлтийг Нийслэлийн иргэдийн хурлаас оруулж явъя гэж байгаа юм.

Утаа. Бид нар жилийн дундаж температур 200 орчим 196-200 орчим хоног нь 15 градусаас доош хэмтэй байдаг ийм хотуудын тоонд ордог юм байна лээ. Тэгэхээр бид нарын дулаан хангамжийн хэрэгцээг цаашид одоогийн байгаа энэ түвшинд нэмэхгүйгээр Улаанбаатар хотод дахиж 1м2 барилга барих дулааны техникийн нөхцөл өгөгдөх боломжгүй болсон.

Тийм учраас бид нар энэ дулаан хангамжийн хэд хэдэн эх үүсвэрүүдийг судалж байна. Одоогийн байдлаар Улаанбаатар хотод 2 байршил дээр тархмал эх үүсвэрийг барьж байгуулах ажил явагдаж байгаа. Цаашид бид нар 10 юун байршилд дулааны тархмал эх үүсвэр барих хэрэгтэй байгаа. Үүнээс гадна бид нар Барилга, хот байгуулалтын яамтай хамтраад, Эрчим хүчний яамтай хамтраад гео теро хайгуулын ажлыг 3 сарын 1-нд эхлүүлэх гэж байгаа. Гео термо буюу газрын гүний дулаанаар дэлхийн улс орнууд дулааныхаа асуудлыг шийдэж байгаа технологи нь дэвшил гараад явж байгаа. Манай урд хөрш дэлхий дээр энэ гео термо дулааны станцынхаа үйлдвэрлэлээр нэгд явж байгаа. Европын хэд хэдэн орнууд яг энэ чиглэлээр явж байгаа. Би бид нар яг энэ чиглэл рүү судалгааны ажил, энэ Төмөрхүү, Даваадалай гээд ажлын хэсэг гарчихсан явж байгаа гэдгийг хэлье. Дүүжин тээврийн ажил.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 6 номерын микрофон нэмж цаг өгье. 1 минут.

Х.Нямбаатар: Дүүжин тээврийн асуудал энэ 9 сар гэхэд дуусна. Тэгээд эхний шугам тэгээд дандаа 6 сар ийм тохируулгын тээвэр хийнэ гэсэн юутай байгаа.

Түрүүн Шижир гишүүн маш сайн мэдэж байгаа. Энэ хууль бусаар газар олголт олгогдсонтой холбоотой асуудлаар тухайн үед Шижир даргыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар ажиллаж байх үед ажлын хэсэг байгуулагдаад Улаанбаатар хотод хууль бусаар олгогдсон бүх газрын тайлан, тооцоо, судалгаанууд гараад, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Улсын ерөнхий прокурор хамтарсан ажлын хэсэг ажилласан. Одоо энэ дээр хууль хяналтын байгууллага ямар процессоор шалгалт шүүлэг явж байгааг би сайн хэлж мэдэхгүй байна. Энэ ажил хяналт шалгалтын ажил үргэлжилж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр Богд ууланд олгогдсон газрууд бүгд хууль зөрчиж олгогдсон. Одоо ч олгогдоор байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дахиад 2 асуулт. Энэ яармагийг Эко Яармаг гээд Шархуу гуай ахлаад ажлын хэсэг ажиллаж байсан. Энэ ажлын хэсэгт байгаа хүмүүс байна уу энэ дотор? Байвал энэ эко чинь хэрэгжиж байна уу, хэрэгжижгүй байна уу? Тэр дундуур явдаг өчнөөн олон зам, тэр үйлдвэрлэлийн бүс энээ тэрээ гэсэн юмнууд чинь хэрэгжиж байгаа юм уу? Ямар бодолтой байгаа юм? Хэрвээ энэ ажлын хэсэгт байсан бол хариулаад өгөөч.

Хоёрдугаарт, Богд уулын хилийн цэсээ яах юм? Одоо тэгээд л ингээд л хуваагаад л яваад байх юм уу? Та нэг зураад л, Байгаль орчны яам нэг зураад л. Ингээд л 2 талдаа зураад ингээд яваад байх юм уу? Хилийн цэсээ өөрчлөх юм уу?

Гуравдугаарт, энэ дүүжин тээврээ та хүлээн зөвшөөрч байгаа юм уу? Яг мэргэжилтнүүд чинь хүлээн зөвшөөрч байгаа юм уу? Эсвэл хэн нэгний автортой болонгуут л тэр хүнийх нь автор нь тэгээд би ийм юм хийсэн гэдэг дээр ингээд гүрийгээд ингээд яваад байх юм уу? Ард, иргэд чинь хүлээн зөвшөөрч байгаа юм уу? Судалгаагаар зөвшөөрөгдөж байгаа юм уу? Яг ТЭЗҮ-ээ зөвшөөрч байгаа юм уу дүүжин тээвэр чинь? Одоо ингээд хийгдээд явах юм байна л даа. Энэ дээр хариулаадхаач.

Х.Нямбаатар: Улсын Их Хурлаар Франц улстай байгуулсан зээлийн хэлэлцээр батлагдаад, Засгийн газрын хооронд гэрээ хэлцлүүд байгуулагдаад, санхүүжилт нь хийгдээд явчихсан зүйлийг би Хотын даргын хувьд Их Хурлын баталчихсан олон улсын зээлийн хэлэлцээрийг би үгүйсгэх ямар ч эрх хэмжээ байхгүй.

Нэгэнт гэрээ хийгдчихсэн учраас энэ ажлыг 1 дүгээр шугамыг нь ямар ч байсан дуусгая гэдэг ийм зарчимтай ажиллаад, ажлыг нь нэлээн шуурхайлсан. Бүх тоног төхөөрөмжүүд нь ороод ирчихсэн. Энэ 4, 5 сараас угсралт хийгдээд 9 сар гэхэд эхний шугамд дуусахаар байгаа.

Хоёр дахь нь Богд уулын холбоотой 4000 гаран га газрын хилийн цэсийн маргаантай асуудал байдаг. Өнгөрсөн жил бид нар бас тодорхой хэмжээний тэр хилийн цэсийн ялангуяа тэр морин тойруулгын урд талын хэсгийн хилийн цэсийн маргааны асуудлыг эцэслэсэн.

Өнгөрсөн жилийн 5 дугаар сард миний бие Богд уулын энэ хилийн цэсийг шинэчлэн тогтооё. Суурьшсан энэ айл өрхүүд суурьш.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 6 номерыг сунгая.

Х.Нямбаатар: Хотын төв, Улаанбаатар хотын суурьшилд авъя. Энэ нэгэнт орон сууцын хороолол баригдсан газрыг хот өөрийнхөө суурьшилд аваад дэд бүтэц, эрүүл мэнд, боловсрол, хот нийтийн аж ахуйгаар хангая гэсэн. Харамсалтай нь Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороон дээр энэ асуудал уначихсан. Энийг цаашид бид нар бас дахиж Засгийн газарт энэ асуудлаа танилцуулъя гэж байгаа.

Таны хэлж байгаа тэр Шархүүгийн үед төлөвлөсөн Яармагийн тэр төлөвлөлт үндсэндээ будаа болсон. Одоо бид нар Дэлхийн банкны санхүүжилтээр 6 эгнээ зам тэр Яармагийн урд талын хэсгээр явуулах гээд газар чөлөөлөлт дээр бөөн асуудал үүсэж үүсэж сая өнгөрсөн намар нэг юм газар чөлөөлсөн. Таны үед бараг хэлэлцээр явж байсан тэр газар Яармагийн 6 эгнээ Дэлхийн банкны санхүүжилттэй замын ажил энэ жил эхэлнэ. Эрчим хүчний гудамж талаасаа шууд гүүрэн зам гарч ирээд Наадамчдын өргөн чөлөө дээгүүр гүүрээр явж байгаад Яармагийн тэр суурьшил дундуур урагшаа Нүхт хүртэл 6 эгнээ хурд.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Там зам явах уу?

Гишүүд асуулт асууж, Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Сайд орж ирээгүй учраас сайдаас асуух асуултаа болиод Байнгын хороон даргаас асууя. Энэ манай Их Хурлын энэ тогтоолын төсөл маань Засгийн газарт Ерөнхий сайдад даалгаж байгаа тогтоолын төсөл байгаа 2 дахь заалт нь тэр чигээрээ. Тэгээд Засгийн газар өөрөө энэ тогтоолын төслийг өргөн барьж байгаа. Хотын дарга хариулах боломжгүй учраас би өргөн барьсан асуудлыг оруулж ирж танилцуулсан Батсуурь сайдаас орж ирэхээр нь асуулт асууя гэсэн. Асуулт асууя гэхэд Байнгын хорооны хурлыг орхиод гараад явчихсан. Засгийн газар маань ийм байдлаар асуудалд хандаад байвал яах юм бэ? Байнгын хороон дарга энэ дээрээ анхаарлаа цаашаа тавихгүй бол түрүүний өөрийн чинь хэлдгээр шипи өгдөг хэдэн хүнээ хэдэн газрын дарга дагуулаад л ороод ирж байна шүү дээ. Засаг дээр явж байгаа томилгоо нь ч байдаг юм уу, илүү дутуу юм нь яг үнэндээ нохойн жогорхой болчихсон л юм байж байгаа шүү дээ. Энэ дээрээ анхаарал хандуулаач. Бид нар Байнгын хорооны хувьд, Их Хурлын хувьд Улсын Их Хурлаас Ерөнхий сайдад даалгаж байгаад тогтоол гаргаж байгаа. Хотын даргад биш. Нэг сайд энд алга. Энх-Амгалан сайд орж ирээд хууч хөөрөөд суучихлаа. Ганхуягийн л буруу байх л даа.

Тэгэхлээр ийм зүйл дээрээ Байнгын хороо болон цаашаа асуумаар байна. Дээрээс нь эргэж орж ирнэ одоохон гээд гүйгээд гарсан Батсуурь сайд одоо энэ асуудлыг нь хэлэлцээд дуусгаад орж ирсэнгүй. Чуулган дээр л асуухаас асуудлыг орохоор.

Ж.Бат-Эрдэнэ: Анхаарья, анхаарья. Дараагийн хурлууд дээр, чуулган дээр яамдын сайд нарыг байлцуулъя. Яамдын сайд нарыг байлцуулъя. Энэ чинь зөвхөн Нямбаатарын ажил биш шүү дээ. Бүх асуудлууд, бүх салбарынхан байж ажлаа бол хариуцаад энэ асуудлыг батлах ёстой.

Батбаатар гишүүний саналыг хүлээж авлаа.

Ингээд асуулт асууж дууслаа.

Төслийн танилцуулга болон үзэл баримтлалтай холбоотойгоор үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Гүйгээд байна уу? Юугаа хийсэн юм уу? Бүртгэлдээ орсон юм уу? Сайнзориг гишүүн. Сайнзориг гишүүнийг оруулья, Сандаг-Очир гишүүнийг оруулья, Ганхуяг гишүүнийг оруулья. Та Өргөөд байна уу, үгүй юу? Үгүй. Ингээд тасаллаа. Номинчимэг гишүүн.\

О.Номинчимэг: Баярлалаа. Тэгэхээр өнөөдөр ингээд бас хүсэн хүлээж байсан Нийслэл хотын иргэдийн бас амьдрал ахуйд нэлээн томоохон бас хөгжлийн чиг хандлагыг нь тодорхойлоход чухал баримт бичиг Төрийн байгуулалтын байнгын хороогоор орж ирж байгаа. Олон ч жил олон ч хүмүүс энэ дээр ажилласан. Тэгэхээр энэ 2040 Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа.

Тэгээд энэ дээр ялангуяа бас тодотгож хэлэх юм бол бас бид өдий хүртэл ер нь бол хот маань уг нь хүн төвтэй, хүн рүүгээ чиглэсэн хүндээ зориулсан хот байх ёстой. Нямбаатар дарга бол энэ ерөнхий төлөвлөгөөний энэ удаагийн онцлог ийм хүртээмжтэй хот байна гэж орж ирж байна. Тэгээд өдийг хүртэл бас бид нарын

явлж ирсэн энэ 30 гаруй жил 90-ээд оноос хойш Улаанбаатарын явж ирсэн юмыг харахаар хүн төвтэй биш, мөнгө төвтэй хот, хотын үйл ажиллагаа байсан. Хэн мөнгөтэй нь дуртай газраа газраа аваад байшин барьдаг, хэн дуртай нь Богдын аманд газар аваад байшин барьдаг, хэн дуртай нь сургууль, цэцэрлэгийн спортын талбай, хүүхдийн тоглоомын талбай барилгүйгээр байшин барьчихдаг ийм л явж ирсэн. Тэгэхээр энийг халж илүү нарийн зохион байгуулалттай, төлөвлөгөөтэй, хууль, эрх зүйн орчин нь уялдаатай, салбарын сайдууд нь бас уялдаатай бодлогоо гаргадаг, төсвөө тавьдаг, ажлаа хэрэгжүүлдэг болохын төлөө энэ баримт бичиг их чухал байгаа юм.

Тэгээд энэ дээр сая Батсуурь сайдын үзэл баримтлалын танилцуулгыг уншиж байхад бас нэг тоо маш чухал тоо байна л даа. Манай иргэд маань бид нар 25 онд ямар амьдарч байгаа юм, 40 онд тэгвэл ямар амьдрах юм бэ гэдгийг энэ тоон үзүүлэлтүүдээр л ер нь харах байх. Тэгээд одоо бол хүнд Улаанбаатар хотод амьдарч байгаа 1 хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ 5м², 2040 хэрэгжсэнээр энэ тоо 35м² болж өснэ гэсэн ийм зорилтыг тавьж орж байгаа юм байна. Тэгээд бид мэднэ. Ер нь 20 минутын хот гэдэг концепцыг гаргаад бид сонгуульд орсон. Үүнийгээ хэрэгжүүлнэ гээд явж байгаа 20 минутын хот гэхээр ерөөсөө л иргэдийн хүсэж байгаа юм бол 20 минутын дотор чанартай сайн сургууль, цэцэрлэг нь, эрүүл мэндийн үйлчилгээ авах газар нь тэгээд ердөө хүүхдүүд нь тоглодог тоглоомын талбай, ногоон байгууламж нь л байгаасай л гэж хүсэж байгаа. Ийм л 3 юм хүсэж байгаа юм. Тэгээд энэ дээрээ л хүн төвтэй бид нар энэ төлөвлөлтөө хийгээд явна, явах байх. Тэгээд үүний дагуу энэ төлөвлөгөө орж ирж байгаа байх гэж харж байгаа.

Тэгээд ногоон байгууламжийн хувьд ярих юм бол ер нь бид бас энэ дээр маш сайн анхаарч, ялангуяа хотын төвд, гэр хороололд ногоон байгууламжийн хүртээмж муутай байгаагаа анхаараад Нямбаатар сайдын даргын хувьд бол бас манлайлаад энэ Төв цэнгэлдэх хүрээлэнг бас Нийслэлийнхээ мэдэлд аваад, бид бас энэ эргэн тойрных нь газрыг нийтийн эдэлбэрт аваад бүүр хамгаалалтад авсан байгаа Засгийн газрын тогтоолоор. Дахиж хэн нэгэнд барилга барих, дахиад тэнд ширэнгэн бетонон ой болгохгүйн төлөө энэ газрыг тусгай хэрэгцээнд авсан байгаа. Тэгээд энэ тусгай хэрэгцээт газраа бид нар ногоон байгууламж, хүүхэд залуучуудын тоглох боломжийг нь нээсэн ийм газар байгаасай л гэдэг энэ алхмуудыг хийсэн байгаа.

Тэгэхээр энэ концепцоо үргэлжлүүлээд бариад бас үүнийхээ дагуу хүүхдүүдийнхээ, залуучуудынхаа тоглох, спортоор хичээллэх боломж, ногоон байгууламж, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг бас харсан хүн төвтэй энэ төлөвлөгөөг бас бид Улсын Их Хурлаас сайн ажиллах ёстой гэж бодож байна. Тэгээд бас нийслэлдээ ажиллаж байсан хүний хувьд, Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүний хувьд энэ ажлын хэсэгт бас орж ажиллах саналтай байгаагаа бас Байнгын хорооны даргадаа хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн үгээ хэлье.

Ц.Сандаг-Очир: Би түрүүнд асуусан асуулттайгаа холбогдуулж саналаа хэлье. Тийм 2040 хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө жоохон сэтгэл гаргаад энэ миний хот, бидний аав, ээжийн хот, миний найз нөхдийн хот, миний ирээдүйн үр хүүхдүүдийн маань хот юм гэдэг жоохон сэтгэл гаргаж энд байгаа Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ анхаарал хандуулж ажилламаар юм шиг санагдаж байгаа юм.

Тэгэхгүй бол өнөөдөр энэ зөвхөн Улаанбаатар хотын ажил гээд хотын дарга, нөхдүүдийн ажил гээд ингээд хаявал магадгүй 15 жилийн дараа ахиад өнөөдрийнх шиг 2020 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 29 хувьтай байсан шиг ийм шалтаг, шалтгаан яриад ингээд сууж байхыг үгүйсгэхгүй.

Тийм учраас энэ алдааг давтахгүйн тулд энэ хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг бүх талаас нь ажлын уялдаа холбоогүй байдал л өнгөрсөн хугацааны алдаа шүү дээ бас. Дур дураараа газар олголтыг яам нь хийдэг, Засаг дарга нь хийдэг, дүүргийн дарга нь хийдэг, хотын дарга нь хийдэг гээд ингээд ерөөсөө ямар ч уялдаа холбоогүйгээр ингэж газар олголтын асуудлууд яваад л өнөөдрийн байдлыг бий болгосон шүү дээ. Төсөв санхүүгийн хувьд яг юугаа хийх гээд байгаа юм? Хот нь яг юун дээр нь эх үүсвэрийг нь гаргах юм, улсаас ямар эх үүсвэрийг нь гаргах юм гэдэг, тэгээд цоо шинэ өөр концепц орж ирж байна. Улаанбаатар хотыг цаашдаа ер нь бас жижиглэх, хэсэгчилсэн байдлаар 14 хот болгож хөгжүүлэх энэ асуудал энэ 40 оны хөгжлийн концепцын нэг онцлог нь. Тэгээд энэ талаар манай энэ Засгийн газрын гишүүд, сайд нар ер нь хэр ойрхон мэдээлэлтэй байна вэ? Хэр хүлээн зөвшөөрч байгаа вэ? Өөр өөрийн байдлаар, өөр өөрийн агуулгаар ингэж тайлбарлаж асуудалд ханддаг ийм байвал тэгээд энэ төлөвлөгөө цаашдаа ажил болно гэхэд хоосон цаасан дээр явсан төлөвлөгөө л болж хувирна.

Тийм учраас жоохон сэтгэл гаргаж, энэ ажил дээр ажиллахгүй бол ийм ирцтэй, ийм бүрэлдэхүүнтэй энэ асуудлыг ийм том хөгжлийн төлөвлөгөөг ингэж яримааргүй л байгаа юм. Энэ олон хүмүүсийн хийсэн энэ хөтөлбөр төлөвлөгөө шүү дээ. Хот төлөвлөлт. Дулаан нь яах юм, эрчим хүч нь яах юм, цэвэр, бохир ус нь яах юм, зам харгуй нь яах юм, цахилгаан хангамж нь яах юм, эрүүл мэнд, боловсрол нь яах юм гээд. Энэ чинь хамаarahгүй салбар байхгүй байгаа биз дээ.

Тийм учраас энэ болгон дээр манай Засгийн газрын гишүүд цаашдаа энэ хэлэлцүүлгийн үеэр ач холбогдол өгч, хамтын уялдаа холбоотой л ажиллах хэрэгтэй байна шүү л гэдгийг. Тийм учраас Байнгын хорооны дарга ажлын хэсгээс гадна хэлэлцэх үеэр энэ Засгийн газрын гишүүдийг бас байлцуулах тал дээр нь анхаарал хандуулж ажиллаж өгөөрэй. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ойлголоо. Сайнзориг гишүүн үгээ хэлье.

П.Сайнзориг: Баярлалаа. Энэ хөгжлийн төлөвлөгөөг дэмжиж байгаа юм. Тэгээд өнөөдөр Улаанбаатар хотын асуудал өчигдөр гэнэт үүсчхээгүй асуудал. Бид яах вэ суурин төлөвт шилжээд, хот байгуулаад яг энэ орчин цагийн хот шүү. Энэ дээр их удаагүй ард түмэн. Мэдээж энэ алдаа оноо явж байж бас шийдэгдэж байгаа. Тэгэхдээ зарим сургамжуудыг эрт авчих ёстай байсан, эрт засчих ёстай байсан юмнуудыг бид хэд бас алдаж засаж байгаа, өртөгтэй засаж байгаа. Гашуун ард иргэддээ зарим талаараа бухимдуулж засаж байгаа нь үнэн.

Тэгэхдээ ер нь алсдаа нийтээрээ бас л энэ хотод бас стресс бухимдалгүй, ажлын байртай, орлоготой, эрүүл аюулгүй орчинд амьдрахын тулд бас Улаанбаатар хотынхон энэ тулгамдсан зарим асуудлыг шийдэхээс өөр арга байхгүй.

Ер нь энэ Улаанбаатар хотын хууль, эрх зүйн орчныг мартсантай холбоотой Улаанбаатар хотын энэ хүн амын тэлэлт, төвлөрөл бий болж байгааг анзааралгүйгээр төсөв харамласантай холбоотой ийм л зүйл ерөнхийдөө энэ

өнгөрсөн цаг хугацаанд болж өнгөрсөн. Тэгээд бид энэ хот төлөвлөлтийн том алдаан дээр Улаанбаатарчууд бүх нийтээрээ маш өртөгтэй сургалтад сууж байгаа, эрүүл мэндээрээ хохирч байгаа. Энийг өнөө, маргаашдаа шууд засна гэхэд хэцүү.

Тэгэхдээ өнөө, маргаашдаа дандаа алсыг харсан суурь шийдэл рүүгээ, шинжлэх ухааны үндэстэй, иргэдийн оролцоотой л явах ёстой. Түүнээс биш гал унтрааж, аргалж гоё ганган зүйлийг яриад хэрэггүй. Ерөнхийдөө эрчим хүч, дэд бүтцийн суурь зүйлүүдээ шийднэ гээд энэ концепц орж ирж байгаад маш дэмжиж байгаа юм.

Тэгээд 1 зүйл байгаа. Энэ Богд уулын асуудлыг сая Байнгын хорооны дарга Бат-Эрдэнэ дарга бас хөндөж байна. Энэ дээрээ нэг талдаа жүжиг тавихаа ер нь төрийн байгууллагууд больё гэж байгаа юм. Цэц нь байж байгаа, Нийслэл хотын байр байж байна. Дээд шүүх нь газартай байж байгаа. Тэгээд иргэд нь төрийн байгууллагууд нь хууль зөрчиж газар авчхаад иргэддээ болохоороо юм ярьдаг. Тэгэхдээ иргэд нь ч гэсэн отог нэртэйгээр орон сууц барьчхаад, энд бүгд амьдарч байгаа шүү дээ. Энийг хотын нэг хэсэгт оруулж ирж, бас энэ хот нийтийн үйлчилгээг нь үзүүлэх үедээ үзүүлээд, байгаль орчны хамгаалалтын асуудлаа ямар зохистой байдлаар хийх вэ гээд шийдээд явахгүй бол бид хэд онигоо. Дэлхийн анхны ДЦГ л гэж байгаа юм. Эргээд энэ энэ Богд уулын урагшаа тэлэлт явж байгаатай холбоотойгоор энэ ан амьтны гарц гаргалгаа бас цаашдаа анхаарах ёстой шүү. Экологийн коридорыг нь зөв тооцож авч явахгүй бол энэ дээрээс ан амьтан дайжихад жижиг хортон шавжууд нь дайжна. Ингээд энэ Богд уулын ой ч байхгүй болно ч гэдэг юм уу ийм зүйлүүд байгаа юм.

Тэгэхээр энэ дээрээсээ ерөөсөө Байгаль орчны яамтайгаа бид маш сайн ойлголцоод энэ зүйлүүдээ ингээд шийдмээр байгаа юм. Тэгээд ер нь хотод цаашдаа ногоон байгууламжийг нэмэгдүүлэх асуудлыг сая Номио гишүүн ярьж байна. Үнэхээр бага байгаа. 5-хан метр квадрат. Энэ ДЭМБ-аас өгч байгаа зөвлөмжөөс бага байгаа учраас ийм иргэд уур бухимдалтай, нийгмийн стресстэй, нийгмийн эрүүл мэндийн хувьд хүнд байгаа. Хүн өөрөө байгалийн амьтан учраас 30 минут байгалийн орчинд суучхаад ороход ажиллаж байгаа байр болон гэр орондоо уур уцааргүй ордог юм. Ингэж уур уцаартай орж байгаа учраас гэр бүлийн хүчирхийлэл буурахгүй байгаа юм. Тэгээд наад захын бид нар энд хүн гэдэг амьтан чинь өөрөө байгалийн амьтан. Байгалиасаа холдож болохгүй гэдэг зүйлийг хот төлөвлөлтийнхөө энэ концепц дээр шингээж ярих ёстой юм.

Тэгээд хүүхэд хөгждөг энэ концепцыг хүүхэд хөгждөг тэр бүтээн байгуулалтыг бас анхаармаар байна. Бизнес шинээр үүсдэг тэр дэд бүтцийг бид нар бий болгомоор байна. Түүнээс биш өнөөдөр ерөнхий юм яриад ард иргэддээ зөв мэдээлэл өгөхгүйгээс болоод л ерөөсөө Улаанбаатар хот гэрэл гэггүй болчихсон юм шиг юм яриад байгаа. Энэ дээр бид зөв төлөвлөж чадвал маш богино хугацаанд энэ үүсээд байгаа утаа, түгжрэл, хөрсний бохирдол байдаг юм уу олон зүйлээсээ гарч чадна. Тэгээд хамгийн гол нь энэ хууль, эрх зүйн болон бодлогын зөв тогтвортой орчин, вишн/vision/тэй байх ёстой. Энийг оруулж ирж байгаа. Энэ бодлогын бичиг баримтыг цаг алдалгүй бас батлаад явуулсан гэж бас хүсэж байгаа юм тэгээд. Хотын асуудал гэдэг хот төлөвлөлтийн асуудал гэвэл хүний эрхийг хангах механизм, зах зээл эдийн засгийн хуваарилалт.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ганхуяг гишүүн үг хэлнэ.

Х.Ганхуяг: Ер нь урт хугацаанд бид нар энэ хотынхoo хөгжлийг хэрхэн яаж харж байгаа вэ гэдэг бодлогын бичиг баримт өргөн баригдсан байна. Тэгээд энэ асуудлыг цаашдаа бид нар дэмжээд явах нь дамжиггүй. Өнгөрсөн 34 жилийн хугацаанд үндсэндээ үүссэн асуудал ерөөсөө л энэ улс төрийн, төрийн тогтолцооны гажуудлаас болсон шүү дээ. Ер нь 76 гишүүний гуравны хоёр нь орон нутгаас сонгогддог. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 3 нэр нь орон нутаг руугаа хийгдчихдэг. Гадаадын зээл, тусламжийн дийлэнх хэсэг нь орон нутаг руугаа хийгдчихдэг. 1000 хүн амтай сум нь 640 хүүхдийн сургууль бариад л явж л байсан. 50 хувийн дүүргэлттэй баахан цэцэрлэгүүд Дархан хотоор дүүрэн л байна гэх мэтчилэн асуудлуудаас болоод л яг энэ цаг хугацаандаа хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалт хийгддэг байсан бол өнөөдөр Улаанбаатар хотын иргэн үндсэндээ Үндсэн хуулиар эдлэх ёс ёстой эрхээ өдэлж чадахгүй байгаа. Тэр сургуулийн орчин нь алга байна. Сургуулиуд нь ч алга байна. Эмнэлгийн хүрэлцээ нь ч муу байна. Соёлын үйлчилгээгээ ч авч чадахгүй байна. Одоо бид нар чинь сум болгон соёлын төвтэй тэгсэн мөртөө Улаанбаатар хотод болохоор хэдхэн 2, 3-хан л кино театртай л байж байна шүү дээ. Тэгээд л тэр үйлчилгээгээ авахын тулд нөгөө автобусандaa суудаг, түгжирдэг ийм нөхцөл байдалтай л байна. 1'500'000 хүн амтай бусад дэлхийн жишигийн хотууд чинь 12-15 мянган км-ийн авто замтай хучилттай авто замтай байхад манайх 1300км-ийн л авто замтай байж байна. Тэгээд нөгөө дэд бүтэцдээ ч хөрөнгө оруулалт хийгдэггүй, хүнд нь ч хөрөнгө оруулалт хийгдэггүй. Нийслэлийн цуглуулсан татварыг улсын төсөв гээд л ийшээ сум ингээд л тавьсаар байгаад л өнөөдрийн нөхцөл байдал яг үндсэндээ яг хамгийн эгзэгтэй мөч дээрээ л ирчхээд байгаа юм л даа.

Тэгэхээрээ цаашид энэ ерөнхий төлөвлөгөөний бичиг баримтыг ерөнхийдөө харсан л даа. Нэлээн бас дажгүй, олон талаас нь харсан байна лээ. Тийм. Тэгэхээр энэ ажлын хэсэг дээр би Байнгын хорооны даргаас бас хүсэлт тавих гэсэн юм. Энэ хотоос сонгогдсон гишүүдийг түлхүү оролцуулах, мэдээж яг жагсаалтын гишүүдээс яг энэ хот төлөвлөлтийн юугаар мэргэшсэн гишүүдийг оролцуулах, ингэж байж бас жоохон тийм бодитой, үр дүнтэй энэ бичиг баримт болох болов уу гэж итгэж байна. Тэгээд энэ дээр бас Байнгын хороон дарга маань анхаараад өгөөрэй л гэж хүсэх гэсэн юм. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Саналыг хүлээж авч байна. Лувсанжамц гишүүн үгээ хэлье.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе.

6 сараас хойш бас Нийслэлтэй, Ерөнхий архитектуртай, Зураг төсөл, судалгааны институттэй, Баттөмөр ажлын албаны даргатай бараг 7 хоног шахуу, 2 долоо хоног шахуу суугаад мэргэжлийн хүний хувьд бол маш олон зөвлөгөөнүүд өгөөд ингээд явсан. Хамтарч ажилласанд маш их баярлалаа. Нэлээн сайн нямбайруулаад, чамбайруулаад өргөн бариад ороод ирж байна. Зарчмын хувьд дэмжиж байгаа.

Мэргэжлийн хүний хувьд өнөөдөр энд байгаа гишүүддээ уг нь сайд нар нь бас байх ёстой байсан. Тэр талаар бас хэдэн уг хэлье гэж бодож байна. Байнгын хорооны дарга сая хэлж байсан. Ерөнхий төлөвлөгөө, ялангуяа Нийслэлийн ерөнхий төлөвлөгөө гэдэг бол нийгмийн гэрээ, бараг Үндсэн хуультай дүйцэх зүйл. Ерөнхий төлөвлөгөөнөөсөө хамаараад бид нарын дараагийн 15 жилийн амьдрал ямар байх вэ гэдэг шийдэгдэх гээд байгаа юм. Монгол Улс яагаад, Улаанбаатар хот яагаад өнөөдөр ийм хөгжилгүй, дэд бүтэцгүй, утаа нь яг ингээд угаартаад, түгжрэлтэй байж байгаа энэ бүх шалтгаан нь бол ерөөсөө ганцхан зүйл байгаад

байгаа. Нэгдсэн төлөвлөлтийн тогтолцоо гэдэг бид нарт тийм зүйл байхгүй байгаад байгаа. Том толгойтой инженерүүд, газрын албаны дарга нар, архитектурууд, Байгаль орчны яам гэх мэт байгууллагууд нь өөрийнхөө салбарыг тусад нь авч яваад, тусдаа төлөвлөгөө зохиогоод байдаг. Нийслэл дээр очоод ярьж байхад олон асуудал байсан. Ерөнхий төлөвлөгөө зохионо гээд явж байхад авто замын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө бас зохионо, нийтийн тээврийн стратеги төлөвлөгөө зохионо, дэд бүтцийн төлөвлөгөө зохионо гээд ийм их олон төлөвлөгөө байхлаар энэ чинь төлөвлөгөө нь утгаа алдаад нийгмийн гэрээ биш болоод аль нь ч хэрэгждэггүй. Ерөөсөө цорын ганц төлөвлөгөөтэй байх ёстой байгаад байгаа юм. Van plan политики/one plan policy/ гэж нэрлэж байгаа. 20 жилийн өмнөөс дэлхийн олон улсын хотод энэ жишиг рүү шилжээд явж байгаа.

Хотын дарга сая хэлж байна. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө байхгүй байсан гээд. Энэ яг үнэн. Яагаад хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө зохиодоггүй вэ гэхлээр өмнөх үе үеийн ерөнхий архитектурууд өөр дээр эрх мэдлийг авахын тулд ийм заваарсан ажил хийдэг байхгүй юу. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө байхгүй болохлоор тухайн газар дээр 5 давхар байшин барих уу, 10 давхар байшин барих уу гэдгийг нь Ерөнхий архитектур шийдээд байгаа. Тэгээд л ширээн доогуураа хэдэн цаас аваад л, том том хотхон хорооллуудад байшинг нь барьж өгөөд л, газрыг нь олгоод л. Тэгээд сургууль, цэцэрлэгүүд нь ингээд ногоон байгууламж нь хүрэхгүй болчдоод байгаа юм. Даргын гарын үсгээр явдаг биш нийгмийн гэрээ буюу нэгдсэн 1 төлөвлөлттэйгөөр. Одоо 14 хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүд бас орж ирэх юм. Эд нарыг бас богино хугацаанд эд нар зохион байгуулаад, боловсруулаад батлах ёстой. Энэ тогтолцоо руу шилжихгүй бол бид нар болохгүй.

Хоёрдугаар зүйл нь байгаад байгаа юм. Үр дүнд сууринсан төлөвлөгөөний тогтолцоо. Энэ дээр маш сайн тодорхой бичсэн байна. Түгжрэлийг шууд 40 хувь бууруулна. Утааг 68 хувь бууруулна. Нийгмийн гэрээнийхээ дагуу амлалтаа өгч байна шүү дээ. Энэ бол маш сайшаалтай зүйл. Тэрийгээ дагасан төсөл, хөтөлбөрүүд юу байх вэ гэдгийгээ бас төслийн жагсаалтаа гаргаж өгч байна. Одоо нэг зүйл дутуу байгаад байгаа нь эрэмбээ гаргаж өгөх ёстой шүү. Энийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө дээр анхаарарай гэж бодож байна.

Хамгийн сүүлд нь Байнгын хорооны даргад санал тавимаар байна. Мэргэжлийн хүний хувьд ажлын хэсгийг ахалж ажилламаар байна. Яагаад заавал Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ингэж явах ёстой юм бэ. Эдийн засгийн байнгын хороо ч гэсэн хот байгуулалтын асуудлуудыг, барилгажуулалт, орон сууцын асуудлыг хариуцаж байгаа. Төрийн байгуулалт руу оръё гэж уг нь саналаа өгсөн. Тэгээд том дарга нар ордог л юм шиг байна лээ. Эдийн засаг дээрээ үлдсэн. Ажлын хэсгийг ахалж ажиллажаа гэсэн тийм саналтай байна. Боломжгүй бол ажлын хэсэгт нь орж ажиллажаа. Одоо Шинэ Хархорум хотын ажлын хэсэг дээр ажилласан. Сүүлийн 3 хоног шөнө 12 өнгөртөл хуралдсан бид нар. Мэргэжлийн зарчимтай зоригтойгоор ажиллана гэдгээ амлаж энэ ажлын хэсгийг ахлуулж өгнө үү гэсэн хүсэлтэй байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ойлголоо. Ганц, хоёр санал байна. Мэдээж ингээд ажлын хэсэг байгуулагдана. Мэргэжлийн хүмүүсээ оролцуулъя, Улаанбаатар хотод бас ажиллаж амьдарч байсан гишүүд маань ч нэлээн байна, салбарын яамнуудад ажиллаж байсан гишүүд маань ч байна, туршлагатай хүмүүс байна. Улаанбаатар хотын захиргаанд ажиллаж байсан гишүүд ч бас байна. Эд нараасаа оролцуулаад тэгээд нэлээн том ажлын хэсэг гарах байх. Тэгээд харах ёстой. Ер нь бол

Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг Улсын Их Хурлаар хэлэлцэж, Улсын Их Хурлын хууль болгож баталж байна гэсэн энэ концепц бол анхнаасаа бас энд хуулиар, хууль болгож ямар нэгэн өөрчлөлт гарахгүйгээр үзэж хараад, нэлээн сайн нямбай үзэж хараад, олон яамнуудын хүрээнд, яамнуудын салбаруудын хүрээнд бүгдийг нь ингээд бүхэлд нь томд нь, сая Лувсанжамц гишүүний хэлдэгчлэн том утгаар нь бол харж байж төлөвлөлтөө бол хийгээд ингээд батлаад хууль болгоод явъя. Тэрийг бол хэн нэгэн эрх мэдэлтэй дарга, хотын захирагч давхиж очоод өөрчлөөд байдаггүй, хэн нэгэн архитектур давхиж очоод өөрийнхөө санаалаар өөрчлөөд байдаггүй ийм л байдалтай байлгая гэсэн энэ анх концепцоор энэ Хот байгуулалтын хуулиа оруулж ирсэн юм шүү дээ.

Тэгээд энэ ДЦГ-тай холбоотой асуудлууд бас нэлээн гишүүд маань ч ярьж байна. Нямбаатар дарга ер нь хууль санаачлаад л оруулж ирсэн нь дээр байх. Энэ чинь Улаанбаатар хотын нэг хэсэг болчихлоо шүү дээ. Юун ДЦГ битгий хэл энэ чинь хэсэг, төрийн болон төрийн бус байгууллагууд бүгдээрээ л орчихлоо.

Тэгэхээр хотын нэг хэсгийг байгаа бол та бүхэн энэ төлөвлөлтөө хийгээд цаашаагаа хот байгуулалтынхаа хэмжээнд бол явах ёстой. Ташрамд хэлэхэд би бол Улаанбаатар хотод болон энэ салбар дээр ажиллаж байгаа хот байгуулалтынхандаа итгэж байгаа юм. Энэ удаагийн хот байгуулалтын энэ концепц энэ өөрчлөлт бол бас тодорхой хэмжээнд түрүүн Нямбаатар дарга ч хэллээ бид өөрсдөө хийсэн гэж. Бид өөрсдөө хийж чадна. Бүх мэргэжилтнүүд байгаа. Ганцхан будилуулдгаа л больших хэрэгтэй байхгүй юу даа. Түүнээс биш бүгдийг нь бид нар төлөвлөж чадахгүй юм биш шүү дээ. Бид бүгдийг нь төлөвлөж чадна. Хот байгуулалтынхаа энэ төлөвлөгөөг хийж чадна. Тийм болохоор та бүхэн бас нэлээн өндөр түвшинд гайгүй хийж орж байсан болов уу гэж найдаж байна. Тэгээд архитектураас авхуулаад нэлээн мэргэжлийн түвшний хүмүүсээ бас татаж оролцуулсан байгаа гэдгийг бол бас харж байгаа.

Утаатай холбоотой асуудал тэр газ руугаа орно уу, хий рүүгээ орно уу одоо ерөөсөө бид нар сүүлийн вариантаар, хамгийн эцсийн юмаа түлхэх цаг болсон Нямбаа даргаа. Энэ рүүгээ орох хэрэгтэй байна. Алийн болгон эд гэрийн дулаалга энэ тэрээ, яндан, зуух, түлш гэж хэдэн жил явах вэ? Хэдүүлээ үүгээ нэгдүүгээрт ормоор байна.

Хоёрдугаарт, түгжрэлтэй холбоотой асуудал, тэр давхар замтай холбоотой асуудлуудыг хийе. 2 түвшний уулзварууд хаана хаана байх ёстой юм? Тэд нар руугаа бүгд рүү нь орьё. Тэгээд баахан шүүмжлээд гадуур яваад байдаг. Дуутай шуутай энээ тэрээ хотын өнгө үзэмжийг алдагдууллаа гээд. Тэр хотын өнгө үзэмж гэхээсээ илүү хүний эрх, эрх чөлөө бүх юмнууд чинь хаагдаад боогдоод аль хэдийн замбараагүй болчоод байна шүү дээ.

Тийм болохоор 20 минутын хот гэдэг концепцоо хийхийн тулд ямар хэмжээний энэ түгжрэлийг сааруулж бууруулах ёстой юм. Бүхий л инженерийн байгууламж бүх юмаа одоо ашиглая гэдэг рүүгээ л орцгоо. Энийг бас санаачлаад ороод ирнэ биз. Тийм.

Тэгээд эрчим хүчний эх үүсвэр. Бид Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулаад үндсэндээ бол бас том шинэчлэл хийсэн шүү дээ. Энэний чинь концепц нь бол ерөөсөө бид нар улсын хэмжээний энэ том том асуудал руугаа бол ордог байя. Зөвхөн 76 тойрог руугаа юмнуудаа чирээд 76 хуваагаад байдгаа больё гэдэг ийм том концепц явж байгаа шүү дээ.

Тийм болохоор энэ эрчим хүчний өөрийн чинь хэлсэнчлэн тэр эх үүсвэрүүд, ямар ямар эх үүсвэрүүд байх юм тэрийгээ эх үүсвэрүүдээ хийгээд явъя. Тэгээд ажлын хэсгийн хүрээнд бол олон асуудлуудыг бас харах ийм боломж, бололцоо гарах байх л гэж бодож байна. Ийм зүйлүүдийг та бүхэнд хэлье. Тэгээд ажлын хэсэг дээр хамтраад ажиллана. Мэдээж дэд ажлын хэсэг бол байгуулагдаад та бүхнээс оролцоод ингээд явах нь зүйтэй байх гэж бодож байгаа.

Яах юм, яах юм шторк үзүүлье гээд байгаа юм байна. Тэрийг ажлын хэсэг дээр үзээд, тэгээд дараагийн асуудал болгоод явчихъя хэдүүлээ.

Одоо ингээд санал хураалт явагдана. Тийм, хэлэлцэх эсэх асуудлаар.

“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүнээс 8 гишүүн оролцож, 53.3 хувиар санал дэмжигдлээ.

Санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганд Номинчимэг гишүүн уншин танилцуулна.

Зарчмын зөрүүтэй саналууд байна уу?

Дараагийнхаа асуудалд орьё.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн заалтад холбогдуулан ажлын хэсэг оролцуулъя.

15.43 цаг

“Тогтоолын хавсралт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төслийн Засгийн газрын өргөн мэдүүлсэн 2024 оны 12 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийг оруул оруулья. С.Батболд Зам, тээрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Итгэлт Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга, Д.Мөнхбат Зам, тээрийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын Төмөр замын тээврийн хэлтсийн дарга, С.Мяндасмаа Зам, тээврийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Т.Жавхлан Зам, тээврийн төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн, Б.Цэнд Зам, тээврийн яамны Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, ахлах шинжээч. Ажлын хэсгийнхнийг оролцуулъя, дуудъя.

Энэ чинь танилцуулга явахгүй юу, байхгүй юу?

“Тогтоолын хавсралт нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй, заалттай холбогдуулан асуулт асуух саналтай гишүүд байна уу? Төмөр зам. Төмөр замын агентлагтай холбоотой асуудал.

Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа юм байна.

Одоо энэ дээр санал хураана шүү дээ.

Тогтоолын төслийн дагаж мөрдөх хугацааг Төмөр замын тээврийн тухай хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан бөгөөд уг хууль 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Уг тогтоолын дагаж мөрдөх хугацаа нь бусад буцаж үйлчлэхээр байна. Тийм болохоор тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн ийм саналыг Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт гишүүн гаргаж байна.

Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналын томьёолол оруулж ирж байна.

Бусад Байнгын хороонууд давхар хуралдаад байгаа. Бусад Байнгын хорооноос гишүүдээ дуудаарай. Зэрэг зэрэг хуралдацаагаад байна.

Сайд нарыг дуудаарай.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцууллаа. Санал хураалт явуулья.

Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүнээс 9 гишүүн санал өгч, 60 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ. Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Сандаг-Очир гишүүн унших уу?

Сандаг-Очир гишүүн уншъя. Дараагийн асуудал. Айн?

15.53 цаг

“Жамсрангийн Самбууний алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулъя.

Эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгатай дахиад уншчих уу?

Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга гэж.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, энэ чинь юунд танилцуулах ёстой юу?

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбал нарын 101 гишүүнээс 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Жамсрангийн Самбууний алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу “Жамсрангийн Самбууний алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг тогтоолын төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр уг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Жамсрангийн Самбууний алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг бэлтгэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд, хандуулсанд баярлалаа.

Ийм танилцуулга байна. Ингээд танилцуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Танилцуулгатай холбоотойгоор уг хэлэх гишүүд байна уу?

Алга байна

Ингээд “Жамсрангийн Самбууний алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга

хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг гишүүн танилцуулна. Дараагийн асуудалд оръё.

15.56 цаа

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулья. Танилцуулга танилцуулгыг уншиж танилцуулья.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврын төсөлд дараах асуудлыг тусгахаар байна. Үүнд:

- 1.Хууль тогтоомжийн биелэлтийн үр дагавар, үнэлгээ хийх асуудал
- 2.Тайлан илтгэл, мэдээлэл хэлэлцэх.
- 3.Төсвийн биелэлтийг хянан шалгах.
- 4.Хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах.
- 5.Хяналт шалгалтын бусад асуудал.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.4 дүгээр хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Байнгын хороод, дэд хороод болон Улсын Их Хурал дахь намын бүлгүүдээс Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврын төсөлд тусгах саналыг авахаар албан бичгийг хүргүүлэхэд дараах байдлаар санал ирсэн болно. Үүнд:

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 6 санал, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 1 санал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2 санал, Инновац, цахим бодлогын байнгын хороо 5 санал, Төсвийн байнгын хороо 5 санал, Хууль зүйн байнгын хороо 4 санал, Эдийн засгийн байнгын хороо 3 санал, Тогтвортой хөгжлийн зорилтын дэд хороо 2 санал, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг 2 санал ирүүлсэн байна.

Албан бичгийн дагуу ирсэн нийт 30 саналаас Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ирүүлсэн 1 санал буюу Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн биелэлтийн үр дагавар, үнэлгээ хийх саналыг Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврын төсөлд дараах үндэслэлээр тусгаагүй болно.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д гишүүний хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийлгэх саналыг холбогдох Байнгын хороо дэмжсэн бол энэ хуулийн 8.3-д заасан санал тусгуулан шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Байнгын хороо дэмжсэн асуудал байхгүй тул Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврын төсөлд тусгаагүй болно.

Мөн Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт нам, эвслийн бүлэг цаглаварт тусгуулах саналаа Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ гэж заасны дагуу 2 санал ирсэн.

Энэхүү 2 саналыг Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврын төсөлд тусгасан тохиолдолд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар хэрхэн хэлэлцэх асуудал нь тодорхойгүй тул Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврын төсөлд тусгаагүйгээр хэлэлцэхээр оруулж ирлээ.

Иймд Байнгын хороо, Дэд хорооноос ирүүлсэн 27 саналыг Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврын төсөлд тусгасан.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх 2 асуудал, Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх 3 асуудал. Ингээд нийт 5 асуудлыг дээр дурдсан 27 санал дээр нэмж нийт 32 санал, асуудал Монгол Улсын Их Хурлын 25 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврын төсөл тусгаж боловсрууллаа.

Нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 2 асуудал.

1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.9-д Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр гэж заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайлан.

2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.10-д Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр гэж заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайлан.

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 3 асуудал

1.Төрийн албаны зөвлөлийн тайланг хэлэлцэх.

2.Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх.

3. Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн явцын тайланг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн хэлэлцэх.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврын төсөлд 32 саналыг тусгаж боловсруулсан болно.

Ингээд “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэх асуудалд холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу?

Өөр нэг санал. Сая 37 санал орж ирсэн. Тэрнээс дахиад 1 санал орж ирж байгаа юм байна. Төрийн байгуулалтын байнгын хороон дарга Ж.Бат-Эрдэнэ танаа

Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатараас ирсэн байна.

Санал хүргүүлэх тухай,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт дараах саналыг тусгуулахаар хүргүүлж байна.

Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай тогтоолын хэрэгжилт, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн биелэлтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан.

Ингээд 2 тогтоолын хэрэгжилт, хоёрдугаарт үнэлгээний тайлан гэсэн энэ 2 тайланг оруулья гэсэн санал ирж байгаа юм байна.

Саяын 37 дээр энэ 2-ыг нэмье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулах уу? Санал хураалт явуулъя.

15 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 53.3 хувиар санал дэмжигдлээ. И

Ингээд цаглаварт орох асуудлууд маань 39 боллоо тээ? 39 санал боллоо.

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг

чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт гишүүд.

Санал хураалтад 15 гишүүн оролцож, 15 гишүүнээс 7 гишүүн оролцож 46.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Учрал гишүүн Учрал гишүүний микрофоныг нээе.

Н.Учрал: Сая санал хураалтад хоцроод орчихлоо. Тэгээд саналыг дахиж хураалгаж өгнө үү гэсэн саналтай байна.

Ж.Бат-Эрдэнэ: Та дэмжиж байгаа юм байна тээ?

Н.Учрал: Тийм, би дэмжиж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгвэл Учрал гишүүний гаргасан саналын томьёоллын дагуу санал хураалтыг дахин явуулья. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн санал хураалт явуулья. Санал хураалт.

15 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 53.3 хувиар санал хураалт саяын санал хураалтад хүчингүйд тооцогдоо.

Ингээд санал хураалтыг дахин явуулья. Санал хураалт.

15 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай “Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Баярбаатар гишүүн танилцуулна.

Ингээд Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай асуудлыг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа орьё.

16.06 цаг

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулгыг та бүхэнд уншиж танилцуулья.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг оруулна гэж, 5.4 дэх хэсэгт Төрийн байгуулалтын байнгын хороо дараагийн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаарх нам, эвслийн бүлэг, Байнгын хороо, Дэд хороо, хууль санаачлагчдын саналыг нэгтгэн зөвлөлд танилцуулах бөгөөд Зөвлөлийн саналыг харгалзан Улсын

Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, цаашид тогтоолын төсөл гэхийг боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар тогтоолын төслийг батална гэж, 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэгт Байнгын хороо боловсруулан Улсын Их Хуралд оруулах асуудлыг энэ хуулийн 45.2, 45.3, 45.4-д заасан журмын дагуу хэлэлцэнэ гэж тус тус заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүдээ,

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Баярлалаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу?
Нэрсээ өгнө үү.

Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлах нь зүйтэй гэсэн томьёоллоор саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

Санал хураалтад 15-8 гишүүн оролцож, 53.3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар танилцуулна. Нэг мөр л танилцуулья гэж бодож байна.

Дараагийн асуудалд, Улсын Их Хурлын Монгол Улсын Их Хурлын 25 оны ээлжит хаврын ээлжит чуулганы хэлэлцэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа орьё.

16.09 цаг

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулья.

Ажлын хэсгийг оруулья. Ажлын хэсгийг танилцуулья. Н.Учрал Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Улсын Их Хурлын гишүүн, Б.Батцэцэг Засгийн

газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга, Х.Сүрэнхорол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт, Н.Нацагдорж Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, Б.Энхсайхан, Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны зөвлөх, Б.Амарсанаа, Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, М.Мөнх-Эрдэнэ, Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны хуулийн мэргэжилтэн гэсэн байна. Тэмүүлэн гишүүнийг дуудаарай.

Ажлын хэсгийн танилцуулгыг Тэмүүлэн танилцуулна. Тэмүүлэн гишүүнийг дуудаарай.

Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Тэмүүлэн гишүүн танилцуулъя. Тэмүүлэн гишүүний микрофоныг нээе. Тэмүүлэн гишүүн танилцуулгаа.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны дарга болоод Байнгын хорооны гишүүддээ бас энэ өдрийн мэндийг хүргэе.

Хархорум бүтээн байгуулалт хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй холбогдуулаад ажлын хэсгээс гаргасан бас санал болоод саналын талаарх санал, дүгнэлтийг та бүхэнд бас уншиж танилцуулъя.

Энэ хуулийн төслийг өнгөрсөн онд 12 сарын 28-нд Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцээд хэлэлцэх эсэхийг дэмжигдсэнтэй холбогдуулаад бол Улсын Их Хурлын даргын 2025 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 1 дүгээр захирамжаар энэ төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг бол байгуулсан байгаад байгаа.

Миний бие ахлаад, ингээд ажлын хэсгийн гишүүддэд Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Улсын Их Хурлын гишүүн Анаар, Батнайрамдал, Батсүмбэрэл, Бум-Очир, Ганбаатар, А.Ганбаатар, С.Ганбаатар, Ганбат, Жаргалсайхан, Замира, Заяабал, Лувсанжамц, Лүндэг, Мөнхтулга, Найдалаа, Отгонбаяр, Пунсалмаа, Уянгахишиг, Хосбаяр, Да.Цогтбаатар, Энхцэцэг, Эрдэнэболд нарын бүрэлдэхүүнтэйгээр бол ингээд байгуулаад ажилласан байгаад байгаа.

Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.5 дахь заалт, мөн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг үндэслээд Улсын Их Хурлын Тамгын газраас бол бас яг энэ өргөн баригдсан хуулийн төсөлтэй холбогдуулж хууль зүйн дүгнэлтийг бол гаргасан байгаад байгаа. Энэ хүрээнд бас ажлын хэсэг бас ажиллаж эдгээр Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн газраас гаргасан энэ хууль зүйн дүгнэлтийг бол тодорхой хэмжээнд үндэслэж энэ дүгнэлтэд тусгагдсан асуудлуудыг бас шийдвэрлэх чиглэлээр бол ажилласан гэдгийг бол бас онцгойлж хэлэх байна.

Ажлын хэсэг энэ өнгөрсөн хугацаанд бүрэн бүрэлдэхүүнээр бас 3 удаа хуралдаж, хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн үед гишүүдийн асууж байсан асуулт болоод тавьж байсан асуудлууд дээр, мөн гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын хүрээнд Их Хурлын Тамгын газраас гаргасан хууль зүйн дүгнэлтийн хүрээнд энэ үндсэндээ энэ өргөн баригдсан хуулийн төсөлтэй

холбогдуулж Үндсэн хууль дээрээ бол 55 зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байгаа. 2 найруулгын санал, хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулаад 3 зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгээд ингээд та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны гишүүдэд хэвлэмэл байдлаар бас энэ саналын томьёоллыг бол та бүхэнд бас хүргүүлсэн байгаад байгаа. Ажлын хэсгээс бэлтгэсэн энэ зарчмын зөрүүтэй саналын томьёолол бол агуулгын хувьд бол бас дараах хүрээг бол хамарч байна гэж бол бас ойлгож болно.

Нэгдүгээрт, бид нар энэ хууль дээрээ ,хуулийнхаа нэрэн дээрээ, хуулийнхаа үндсэн агуулга болоод үзэл санаа, концепцууд дээрээ, зүйл, заалтууд зохицуулалтууд дээрээ бол бас нэлээн тусгаж нэмж оруулсан зүйл маань бол энэ хот төлөвлөлтийн асуудлыг бол онцгой нарийвчилж оруулж өгсөн байгаад байгаа. Энэ хүрээндээ зорилго, зарчмуудыг нь тодорхой хэмжээнд тодруулж суурь шинжтэй бас энэ үндсэн зарчмуудыг бол эрэмбэлж ингээд тус тусгасан гэдгийг нэгдүгээрт бас хэлэх байна.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлаас 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр бас баталсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Хот байгуулалтын тухай хуулийн зохицуулалтуудтай хуулийн төслийн зарим хэсгийг нийцүүлэх энэ зохицуулалтуудыг бол бас хийж ажилласан гэдгийг бол бас та бүхэнд хэлэх байна.

Гуравдугаарт, Хотын зөвлөл болон захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэлх хугацаанд бол энэ хотын удирдлагыг хэрэгжүүлэх, зөвлөл захирагчийг Засгийн газар томилох, чөлөөлөх зохицуулалтуудад тодорхой хэмжээний өөрчлөлтүүдийг бол оруулж тусгасан гэдгийг бас хэлэх байна.

Дөрөвдүгээрт, хөрөнгө оруулалтын хэлбэртэй холбоотой, Хөрөнгө оруулалтын тухай хуульд тусгагдсан энэ зохицуулалтын харилцааг бол тухайн хуулиар зохицуулахаар татварын болон татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэг орон нутгийн дэмжлэгийн хэсгийг бол төслөөс ингээд хасахаар бол бас тусгаж оруулж өгсөн гэдгийг бол та бүхэнд бас онцолж хэлэх байна.

Тавдугаарт, хуулийн үйлчлэх хотын оршин суугчийн тоо 10 мянгад хүрч, хуулийн дагуу хотын зөвлөл, захирагч сонгогдох хүртэлх хугацаанд бол үйлчлэх зэргийг бол ингээд хамруулаад оруулж өгсөн гэдгийг бол бас та бүхэнд бас ингээд хэлэх байна.

Ерөнхийдөө ингээд ажлын хэсгээс сая өнгөрсөн энэ 10 орчим хоногийн хугацаанд ажилласан хүрээнд оруулж байгаа өөрчлөлтийг бол та бүхэнд бас товч байдлаар бол танилцуулж байна. Тэгээд та бүхэн маань ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бас хэлэлцээд шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хичээнгүйлэн хүсэх байна.

Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн танилцуулгатай холбоотойгоор асуух асуулт гишүүд байна уу? Асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Би дэг танилцуулъя та бүхэнд. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.10. Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Хэрэв төслийг зүйлээр хуульд шинээр бүлэг, дэд бүлэг нэмэх, бүлэг, дэд бүлгийг бүхэлд нь өөрчлөх бол тухайн бүлгийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

39.11. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно.

Хууль, тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд алга байсан сая.

Ингээд хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Ингээд ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол,

1. Төслийн гарчгийн “ХОТЫН” гэсний дараа “ТӨЛӨВЛӨЛТ,” гэж нэмж, үүнтэй холбогдуулан төслийн 6 дугаар бүлгийн, 26 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 26.1 дэх хэсгийн “хотын” гэснийг “хот төлөвлөлт” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, Ч.Анар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Д.Бум-Очир, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Д.Жаргалсайхан, С.Замира, Б.Заябал, Г.Лувсанжамц, С.Лүндэг, П.Мөнхтулга, Б.Найдалаа, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг, С.Эрдэнэболд цаашид ажлын хэсэг гэх. Санал хураалт.

15 гишүүнээс 8 гишүүний саналыг дэмжиж 53.хувиар санал дэмжигдлээ.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжил, зарчмын зөрүүтэй санал

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1. Энэ хуулийн зорилт нь түүхэн нийслэл Хархорум хотыг сэргээн байгуулж, монгол үндэстний түүх, язгуур өв, нүүдлийн соёл иргэншлийг хамгаалах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, бус нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, байгаль орчинд ээлтэй, хүний ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжих, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Баярмаа гишүүн. Баярмаа гишүүний микрофоныг нээе. Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Горимын санал гаргаж байна. Дахин санал хураалгаж өгнө үү. Сая энэ төхөөрөмж болсонгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүний гаргасан саналын дагуу саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдсэн тул саналыг хүчингүйд тооцлоо.

Санал, дахин санал хураалт явуулья. Санал хураалт.

Санал хураалтад 9 гишүүн оролцож, 15 гишүүнээс 9 гишүүн оролцож 60 хувиар санал дэмжигдлээ.

Хархорин хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр санал, аль? З шүү дээ одоо. Сая хураачихсан шүү дээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль,” гэсний дараа “Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

15 гишүүнээс 8 гишүүн санал өгч, 53.3 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүнээс 8 гишүүн оролцож, 53.3 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим

4.1.Хотыг төлөвлөх, бүтээн байгуулах, түүний хөгжлийг дэмжихэд Хот байгуулалтын тухай хуулийн 4.1-д зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

4.1.1.Монгол үндэстэн, угсаатны уламжлалт үнэт зүйл, түүх, соёлын биет болон биет бус өвийг сэргээх, хадгалан хамгаалах;

4.1.2.түүх, соёлын дурсгалт газар, археологи, соёлын биет болон биет бус өв, байгалийн онцлог, нүүдлийн соёл иргэншилд түшиглэн олон төрөлт тогтвортой аялал жуулчлалыг дэмжих;

4.1.3.бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангаж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдсан, эдийн засгийн хувьд Хангайн бүсийн хөгжлийг дэмжиж, бие даан хөгжих боломжтой байх;

4.1.4.тогтвортой хөгжлийн зорилтыг хангах хөрөнгө оруулалтыг дэмжих;

4.1.5.хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, үйл ажиллагаа оршин суугчийн нийтлэг эрх, ашиг сонирхолд нийцсэн, нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, хүмүүнлэг, олон төвт хотын тогтолцоог хөгжүүлэх;

4.1.6.дэвшилтэт технологи, инновацад суурилсан, ухаалаг дэд бүтцийг хөгжүүлэх;

4.1.7.эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийг дэмжих,

4.1.8.сэргээгдэх эрчим хүчний олон төрлийг дэмжих;

4.1.9.орчны аюулгүй байдлыг хангаж, гамшгаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.10.Улаанбаатар хот болон бусад бүс нутагтай холбогдох зорчигч болон ачаа тээврийн сүлжээг хөгжүүлэх.” . Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

15 гишүүнээс 9 гишүүн дэмжиж 60 хувиар санал дэмжигдлээ

6.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Хотын эрх зүйн үндэс

5.1.Хот нь улсын зэрэглэлтэй байна.

5.2.Хотын захирагч хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хотыг төлөөлнө.” . Санал гаргасан ажлын хэсэг, Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.Хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох, түүнийг өөрчлөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэх бөгөөд Газрын тухай хуульд заасан эдэлбэр газрын хэмжээ, заагийг баталж, тогтоохтой холбогдох зохицуулалт хамаарахгүй. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Хот нь” гэсний дараа “Хот байгуулалтын тухай хуулийн 11.1-д зааснаас гадна” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “өөрчлөлт оруулах” гэсний дараа “асуудал болон хэрэгжүүлэх дэд бүтцийн төслүүдийн жагсаалтыг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

16 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 62.5 хувиар санал дэмжигдлээ.

10. Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг 7.4, 7.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

7.4. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн бүтээн байгуулалтын үе шат бүрээр хамт боловсруулах бөгөөд хотын Зөвлөл батална.

7.5. Төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Сандаг-Очир өгсөнгүй, Учрал өгсөнгүй. Санал хураалтад оролцсонгүй. Сандал-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Саяын санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хурааж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Сандал-Очир гишүүний гаргасан саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

Санал хураалтад 16 гишүүнээс 10 гишүүн оролцож, 62.5 хувиар санал дэмжигдлээ.

11, хүчингүй тээ? Санал хураалтыг дахин явуулья. Санал хураалт.

Болсонгүй юу? Шижир гишүүн.

Ө.Шижир: Сая би саналаа өгч амжсангүй. Тэгээд дахин санал хурааж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Шижир гаргасан саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

Яасан бэ? Туваан сайд, Туваан гишүүн.

Ц.Туваан: Төхөөрөмж ажилласангүй тул саяын санал хураалтыг хүчингүй болгож өгч, дахин санал хураалгаж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Туваан сайдын гаргасан саналын дагуу саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, санал хүчингүйд тооцогдлоо.

Дахин санал хураалт явуулья. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

11. Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “зориулалтаас” гэснийг “зориулалт, хүн амын нягтаршлаас” гэж, 8.1.3 дахь заалтын “1 га” гэснийг “0.1 га” гэж, 8.1.5 дахь заалтын “нягтралыг” гэснийг “нягтаршлыг хэсэгчилсэн ерөнхий

төлөвлөгөө, барилгажилтын төслийн түвшинд” гэж, 8.1.6 дахь заалтын “төлөвлөгөөний шийдэл, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай” гэснийг “баримт бичгүүдтэй” гэж, 8.1.2 дахь заалтын “ногоон хот байгуулах зорилтын хүрээнд” гэснийг “хотын” гэж, 8.1.8 дахь заалтын “байгууламжийн хамт цогцоор нь төлөвлөсөн” гэснийг “байгууламж, инженерийн дэд бүтцийн зурвасыг багтаасан цогц төлөвлөлтөөр шийдсэн” гэж, 8.2 дахь хэсгийн “ухаалаг шийдэл нэвтрүүлнэ” гэснийг “олон улсын ухаалаг хотын стандартад заасан ухаалаг шийдлийг нэвтрүүлж болно” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Туваан гишүүн.

Ц.Туваан: Төхөөрөмж ажилласангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалгаж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Туваан гишүүний гаргасан саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал хүчингүй боллоо.

Санал хураалтыг дахин явуулья. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “орон сууцнаас” гэсний өмнө “нийтийн” гэж, 8.1.7 дахь заалтын “шийдэл нь” гэсний дараа “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгасан гудамжны нийтлэг өнгө, барилгын өндөржилт, загварын дагуу” гэж, 8.1.9 дэх заалтын “саарал усыг” гэсний өмнө “хотын олон нийтийн барилга байгууламж нь” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

16 гишүүнээс 8 гишүүн. Яачихсан бэ? Алтангэрэл гишүүн. Дандаа сайд нар л ерөөсөө энэ техниктэйгээ харьцаж чадахгүй л болчхож байна шүү дээ. Сууж бай л даа.

О.Алтангэрэл: Төхөөрөмж ажилласангүй. Тэгээд санал хураалт явуулж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Алтангэрэл гишүүний гаргасан саналын дагуу саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал хүчингүй боллоо. Санал хүчингүй боллоо. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.15 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.1.18, 8.1.19 дэх заалт нэмэх:

“8.1.18.байгаль экологи, археологи, палеонтологи, нүүдлийн өв, соёл, нутгийн иргэдийн ахуй амьдралд түшиглэсэн, төрөлжсөн аялал жуулчлалыг хөгжүүлэх;

8.1.19.түүх, соёлын дурсгал, урлагийн бүтээлд тулгуурлан үндэсний бахархлыг сэргээж, биет болон биет бус өвийг хадгалан хамгаалах.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.3 дахь хэсэг нэмэх:

“8.3.Хотын ерөнхий төлөвлөгөөг 20 жил, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 5 жилийн хугацаатайгаар төлөвлөх бөгөөд оршин суугч болон аж ахуйн нэгжийн санал, барилгажилтын түвшин, хотын Зөвлөлийн олонхын шийдвэрийг үндэслэнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Хотын нутаг дэвсгэрийн бүсчлэл

9.1.Хотын нутаг дэвсгэр Хот байгуулалтын тухай хуулийн 13.1-д зааснаас гадна дараах бүсчлэлтэй байх бөгөөд эдгээр бүсүүд нь тусгайлан баталсан бүсчлэлийн дүрэмтэй байна:

- 9.1.1.археологи судалгааны бүс;
- 9.1.2.нийгийн дэд бүтцийн бүс;
- 9.1.3.тээвэр, логистикийн бүс;
- 9.1.4.инженерийн дэд бүтцийн бүс;
- 9.1.5.хамгаалалтын бүс;
- 9.1.6.холимог ашиглалтын бүс;
- 9.1.7.нөөц бүс /цагаан газар/.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан бүсчлэлийн дүрмийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр нарийвчлан тодорхойлно.

9.3.Бүсчлэлийн дүрэмд тухайн бүсэд зөвшөөрөгдөх үйл ажиллагааны төрөл, барилга байгууламжийн хэмжээ, байршил, барьж болох барилгын зориулалтыг тусгана.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувийн санал дэмжигдлээ.

17.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.5 дахь хэсгийн “эзэмших,” гэснийг тус тус, 10.3 дахь хэсгийн “ашиглуулахаас” гэсний өмнөх, мөн хэсгийн “ашиглуулах” гэсний өмнөх, 16 дугаар зүйлийн 16.7.6 дахь хэсгийн “эзэмшүүлэх,” гэснийг тус тус хасаж, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах.

Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Энэ 17 дугаар зүйл дээр энэ заалтыг дэмжиж байна. Тэгэхдээ энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль энэ 6 сарын 1-ний шинэчилсэн найруулга дээр 30.1.20 дээр хотын эдэлбэр газарт хууль тогтоомж хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хотын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргах гээд хуулийн заалт байгаа юм.

Тэгэхээр энэ дээр энэ эзэмшүүлэх гэдэг үг чинь энэ дээр нь энэ хасах заалт дээр чинь орчихсон яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр би ямар саналтай байна гэхээр яах вэ энэ заалтаа дэмжихье. Зарчмын зөрүүтэй санал гаргаж болно тээ. Энэ эзэмшүүлэх гэдэг үгийг нь үлдээе гэж. Тэгэхээр яах ёстой юм одоо? Тэгвэл энэ заалтаа бид нар авч үлдэх юм уу? Тийм л арга болох гээд байна шүү дээ. Хуулийн дагуу энэ эзэмшүүлэх гэдэг үгийг нь авч үлдмээр байгаа байхгүй юу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу. Засгийн өргөн барьснаар явна гэвэл энэ заалтаа унагана тэгвэл. Тэгвэл энэ заалтыг дэмжихгүй унагаж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хураалт. 16 гишүүнээс 2 гишүүн дэмжиж, 12.5 хувиар санал дэмжигдсэнгүй.

18. Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “төсөл сонгон шалгаруулах журмаар шийдвэрлэнэ.” гэснийг “дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

19. Төслийн 10 дугаар зүйлийн 10.5.1 дэх хэсгийн “заасан бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхээс” гэснийг “зааснаас” гэж, 10.5.2 дахь заалтын “бүтээн байгуулалтын төслийг” гэснийг “газар ашиглах” гэж, “төлөвлөгөөнд” гэснийг “төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөнд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Учрал гишүүн.

Н.Учрал: Би ажлын хэсгийн саналыг дэмжиж байгаа. Тэгээд сая санал хураалтаас хоцорчихлоо. Саналыг дахин хурааж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Учрал гишүүний гаргасан саналын дагуу горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, санал хүчингүйд тооцогдоо.

Дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ. 20.

Хархорин хотын бүтээн байгуулалтын хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

12 дугаар зүйл. Төслийн 3 дугаар бүлгийн гарчгийг “ХОТЫН ЧИГ ҮҮРЭГ, УДИРДЛАГА” гэж өөрчилж, 12 дугаар зүйлийн 12.1.12 дахь заалтыг хасах. Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

Алтангэрэл сайдыг ирцээс гаргая. Ажилтай гээд явлаа.

Баярмаа гишүүн эмнэлгийн чөлөө аваад явсан. Эмнэлэг явсан. Баярмаа гишүүнийг ирцээс гаргая.

21. Төслийн 13 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

22. Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 35 дугаар зүйлийг хасах:

“14 дүгээр зүйл. Хотын удирдлага

14.1. Хотын удирдлагыг хотын Зөвлөл, Захирагч хэрэгжүүлнэ.

14.2. Хотын байнгын оршин суугчийн тоо 10000 хүрснээр хотын Зөвлөл, Захирагчийн сонгуулийг зохион байгуулна.

14.3. Энэ хуулийн 14.2-т заасан Зөвлөл, Захирагчийн бүрэн эрх хэрэгжиж эхлэх хүртэл энэ хуулийн 14.6, 14.7-д заасны дагуу томилогдсон Зөвлөл, Захирагч хотын удирдлагыг хэрэгжүүлнэ.

14.4. Энэ хуулийн 14.6, 14.7-д заасны дагуу томилогдсон Зөвлөл, Захирагч Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон энэ хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14.5. Зөвлөл нь 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дараах төлөөллөөс бүрдэнэ:

14.5.1. Засгийн газрын санал болгосон гурван төлөөлөл;

14.5.2. Энэ хуулийн 14.7-д заасан Захирагч;

14.5.3. Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас санал болгосон гурван төлөөлөл;

14.5.4. хот байршиж байгаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга;

14.5.5. барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон мэргэжлийн холбоодын хоёр төлөөлөл.

14.6. Энэ хуулийн 14.5.3-д заасан төлөөллийг нээлттэй нэр дэвшүүлж, тэдгээрээс сонгогдсон гишүүдийг энэ хуулийн 14.5-д заасан бусад гишүүдийн хамт Засгийн газар томилж, чөлөөлнө.

14.7. Энэ хуулийн 14.3-т заасан Захирагчийг Засгийн газар томилж, чөлөөлнө.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүй болгоё. Баярбаатар гишүүн асуулт асууна.

Б.Баярбаатар: Ажлын хэсгээс асуулт байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах нь боломжгүй болчихсон юм бол энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль дээр чинь 15 мянга хүрснээр хотын зөвлөл, захирагчийн сонгуулийг зохион байгуулна гэчихсэн байна шүү дээ. Энэ дээрээ 10 мянга гээд оруулчихлаа шүү дээ. Энэ чинь бас хуулийн зөрчилтэй л юм гараад ирлээ. Энэ дээр ажлын хэсэг ямар байдлаар энэ 10 мянга болгосон юм бол? Тэгээд энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиа 15 мянга гэснээс яаж гарах юм бол?

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн ахлагч Тэмүүлэн гишүүн хариулна.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулья. Тэгэхээр энэ анх Засгийн газраас өргөн баригдсан энэ хууль дээрээ хотын байнгын оршин суугчийн тоо 15 мянгад хүрснээр бол энэ хотын зөвлөл болоод захирагчийн сонгуулийг зохион байгуулахаар орж ирсэн. Энийг ажлын хэсэг дээр бид нар бас ярьж байгаад нэг талдаа хууль дээр бас тодорхой өөр бас гарц гаргалгаа бол байна гэж үзсэн. Энэ нь өөрөө Хот, тосгоны тухай хуулийн 11.2 дээр улсын зэргэлдээ хотын хорооллыг бол 10 мянгаас доошгүй оршин суугчтайгаар байгуулах гэдэг заалт бол байгаад байгаа.

Тэгэхээр нэг талдаа бид нар бол бас 15 мянгаасаа илүү наашлуулж 10 мянга болгох. Ингэж байж юу гэдэг юм, нэг талдаа энэ түр зохицуулалтын хууль маань бол бас дуусгавар болоод цэвэр оршин суугчдынхаа төлөөлөл болсон зөвлөл болон захирагчийг бас сонгуулийн хүрээнд зохион байгуулах энэ эрхийг нь бол нээж өгөх нь зүйтэй гэж үзээд хамгийн боломжит тоо буюу хамгийн доод тоо нь бол нэг талдаа хороолол байгуулагдсанаар, 10 мянга хүрснээр бол энэ сонгууль зохион байгуулагдах эрх бол нээгдэж болно гэж бас үзсэн байгаад байгаа.

Үндсэндээ бид бүхэн бас 15 мянга гээд хийгээд үзэх юм бол 10 мянган хүнтэй хороолол байгуулагдаад, дахиад 5 мянган хүн нэмэгдэж байж үндсэндээ бол сонгууль зохион байгуулагдах эрх бол үүсэхээр байгаа юм.

Тэгэхээр бид нар магадгүй үндсэндээ 10 мянган хүнтэй Хот, тосгоны тухай хууль дээр заасан улсын зэрэглэлтэй хотын хороолол буюу 10 мянга гэж байдаг. Бүхэл бүтэн нэг хороолол үүссэн байхад сонгууль явуулахгүйгээр тодорхой хугацаанд хойш нь орхино гэдэг нь бол бас зөрчлийн асуудал юм байна гээд энэ үндсэн дээр бол бас 10 мянга болгоод ингээд бол явсан гэдгийг бол хэлэх байна.

Хотын хороолол бол угаасаа энэ хот байгуулалтын зохион байгуулалтын үндсэн нэгж байгаад байгаа. Тэгэхээр анхных нь буюу суурь нэгж нь байгуулагдсаны дараагаар бид нар сонгууль явуулах энэ эрхийг нь нээж өгөх нь зүйтэй байх гэсэн энэ үндсэн дээр хийж өгсөн.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хураалт.

Номинчимэг гишүүн, Номинчимэг гишүүний микрофон.

О.Номинчимэг: Энэ сая төхөөрөмж бас гацаад тэгээд саналаа өгч чадсангүй. Энэ санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Номинчимэг гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн өгч дэмжиж, 61.5 хувиар санал хүчингүйд тооцогдлоо.

Одоо дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

13-аас 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “зөвлөл, түүний” гэснийг “зөвлөлийн” гэж өөрчилж, мөн зүйлийн 15.2, 15.3, 15.4, 15.5, 15.6 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тэмүүлэн гишүүн. Ажлын хэсгийн ахлагч Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Энэ 15.8 дахь хэсгийг хасах гээд энэ санал бас ажлын хэсгээс орж ирсэн байсан. Нэг талдаа энийг ажлын хэсгээс бас буцаагаад татаж байна. Ажлын хэсгийн гишүүдтэй зөвлөж байгаад энэ саналаа бол татах нь зүйтэй байна гээд ингээд татаж байгаа санал байгаад байгаа. Санал хураалгах шаардлагагүй байх гэж үзэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: 16 руу орж байна шүү дээ. Нөгөөдөх нь унших юм уу, үгүй юм уу?

25.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5 дахь хэсгийг хасаж, 16.6 дахь хэсгийн “алба болон харьяа газрын” гэснийг “албаны” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Эндээс нэг асуулт байна. Энэ 16.1, 16.5 дахь хэсгийг хасаж 16.6 дахь хэсгийн алба болон харьяа газрын гэснийг албаны гэж өөрчлөх гээд. Энэ дээр ажлын хэсгийн ахлагчаас нэг зүйл асуух гэсэн юм. Энэ захирагчийн дэргэд алба байна гэсэн нь хасагдаж байгаа юм уу? Харьяа газар? Тэгэхээр ер нь бол үйл ажиллагаа явуулахын хувьд бол харьяа байгууллагууд жишээ нь авто тээвэртэй

холбоотой асуудлууд, зам, тээвэртэй холбоотой асуудлууд гээд ингээд харьяа байгууллага бол байж байж энэ үйл ажиллагаа явуулна шүү дээ. Энэ хууль чинь бол наанадаж 10 жилийн хугацаанд хэрэгжих ёстай шүү дээ.

Тэгэхээр харьяа байгууллага байхгүйгээр зөвхөн Захирагчийн алба энэ бүх үйл ажиллагааг явуулна гэвэл боломжгүй болчкоод байгаа байхгүй юу. Тэгэхээр ажлын алба, зөвхөн ажлын албаар наадах чинь барахгүй. Зөвхөн ажлын албаар барахгүй. Яагаад гэхээр дэргэдэх байгууллагуудад байж байж жишээ нь, зам, тээвэртэй холбоотой асуудлууд байж байж зам, тээврийнхээ асуудлуудыг шийдээд, замтай холбоотой асуудлуудыг шийдээд ингэж явахгүй бол наадах чинь наадах чинь арай хатуудах байх.

Ажлын хэсгийн ахлагч Тэмүүлэн гишүүн хариулъя. Тэгье.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр бид нар энэ 16.5-д заасан хотын захирагч ажлын алба болон харьяа газартай байна гэдэг заалт дээрээс нь харьяа газартай байна гэдэг нь харьяа газрыг нь бол хассан. Ажлын хэсгийн хуралдаан дээр гишүүдийн олонхоор бол энийг шийдсэн. Энийг өөрөө яагаад бид нар бас үндэслэл болгож оруулж ирсэн юм бэ гэхээр нэгд энэ шинээр орж ирж хэлэлцэгдэж байгаа Хархорин хотын төлөвлөлт болоод бүтээн байгуулалтыг дэмжих тухай энэ хуулийг Хот, тосгоны тухай хуультай нийцүүлэх шаардлагатай гэж бол үзэж ингээд энэ өөрчлөлтүүдийг бол хийсэн байгаад байгаа юм.

Тэгэхээр Хот, тосгоны тухай хууль дээр хот, тосгоны энэ удирдлага зохион байгуулалт, чиг үүрэгтэй холбоотойгоор бол үндсэндээ Хот, тосгоны тухай хуулийн 10.3 дээр энэ хот, тосгоны зөвлөл, захирагч нь ажлын албатай байна гэсэн зохицуулалт бол байгаад байгаа юм. Тэгээд яах вэ бид нар нэг талдаа юу гэдэг юм, энэ харьяа газар гэдэг нэр томьёолол бол Хот, тосгоны тухай хуулиуд дээр бол нэг талдаа байхгүй байгаад байгаа. Үндсэндээ бол Захирагч нь байх гэдэг энэ зохицуулалтын харилцаа бол байхгүй учраас нэг талдаа Хот, тосгоны тухай хуультайгаа нийцүүлээд л ингээд байгаа явах нь бол зүйтэй болов уу гэсэн байдлаар зохицуулалтыг хийж өгсөн юм.

Ж.Бат-Эрдэнэ: Алдаржавхлан гишүүн ажлын хэсгийн гишүүн.

Ж.Алдаржавхлан: Үгүй энэ чинь дэргэдэх байгууллагууд чинь бүгдээрээ босоо байгууллагууд чинь угаасаа байгуулагдаад явна шүү дээ. Захирагч эмнэлэг байгуулна гэж байхгүй шүү дээ. Тэр чинь Эрүүл мэндийн яамнаас харьяа байгуулагддаг биз дээ? Захирагч Цагдаагийн газрын байгууллага гэж байхгүй. Бүгдээрээ тусдаа босоо удирдлагатай байгууллагууд. Хот байгуулагдвал тэд нар байгуулагдана.

Хоёрт нь дэргэдэх тэр TYK гэсэн бүтцээ энэ хүн чинь хотын зөвлөлөөрөө батлуулах эрхтэй. Эрх нь нээлттэй байхгүй юу. Хориглосон юм ерөөсөө байхгүй. Огт хориглосон зүйл байхгүй. Хот, тосгоны хуультай л нийцүүлж байгаа юм. Үгүй. ингэж хаалаа гээд тэр хүн байгуулахгүй байх эрх нь байгаа шүү дээ. Тэгээд тэр Цагдаагийн газрыг чинь Цагдаагийн ерөнхий газар байгуулна.

Б.Баярбаатар: Харьяагаараа байсан нь дээр шүү дээ. Тийм биз дээ? Тийм харьяа байгууллага гэж байна шүү дээ.

Ж.Алдаржавхлан: Үгүй. Тэгээд захирагчийг яаж цагдаагийн газар байгуулах гээд байгаа юм? Үгүй ээ Бат-Эрдэнэ дарга Цагдаагийн газрыг чинь Цагдаагийн ерөнхий газар байгуулдаг. Эмнэлгийн чинь эмнэлэг байгуулдаг.

Ж.Бат-Эрдэнэ: Баярбаатар гишүүн үгээ хэлье.

Б.Баярбаатар: Энэ чинь ер нь одоо бид нар өнөөдөр хуулийг нь батална. Ингээд хот болоод яатал 5, 10 жилийн дараах асуудлыг л өнөөдөр яриад байгаа юм л даа. Тэгээд ер нь энэ чинь харьяа гэж явах ёстой доо. Энэ цагдаа бас энэ хот. Энэ бид нар, би энэ дээр нэг зүйлийг ойлгохгүй байна. Энэ хорооллын хууль яриад байна уу? Хотын хууль яриад байна уу ер нь? Тэгээд би энэ харьяа гэдэг дээр нь байлгамаар байна. Тэгэхээр энэ саналыг дэмжихгүй унагах нь зөв байх аа.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хураалт.

13 гишүүнээс 5 гишүүн дэмжиж санал дэмжигдсэнгүй.

Төслийн 16 дугаар зүйлийн 16.1-ийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүй болгоё. Ажлын хэсгийн ахлагч Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Энэ 26 дахь санал болох энэ 16 дугаар зүйлийн 16.3, 16.4 дэх хэсгийг хасах гээд энэ хотын захирагч түүний бүрэн эрхтэй холбоотой захирамж гаргах, мөн эрхтэй холбоотой заалтууд байгаа. Тэгээд энэ хоёрыг бол буцаагаад, хэвээр нь үлдээгээд ажлын хэсгээс бас зөвлөлдсөний үндсэн дээр энэ 2 саналаа хэвээр нь үлдээе гээд саналаа татаж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: 27.Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.4 дэх заалтын “батлах” гэснийг “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу байгаа эсэхийг шалгах” гэж, 16.7.7 дахь хэсгийн “төлөвлөлтийн даалгаврыг батлах” гэснийг “төлөвлөлтийг хянан зөвшилцэх” гэж, 16.7.9 дэх заалтын “барилга байгууламжийн” гэснийг “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилга байгууламжийн” гэж, мөн заалтын “уялдуулан батлах” гэснийг “уялдаж байгаа эсэхийг хянах” гэж, 16.7.11 дэх хэсгийн “батлах” гэснийг “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу холбогдох байгууллагын дүгнэлтийн дагуу олгох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиараа санал дэмжигдлээ.

28.Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.13 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

29.Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.6 дахь заалтын “бүсчлэл” гэснийг “бүсчлэлийн дүрэм” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13-аас 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

30.Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13-аас 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

31.Төслийн 16 дугаар зүйлийн 16.7.15 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

32.Төслийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

33.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “төлөвлөгөө,” гэсний дараа “бүсчлэлийн дүрэм,” гэж, 17.1.7 дахь заалтын “хот хөгжүүлэх” гэсний дараа “болон хотын дэд бүтцийн” гэж нэмж, 17.1.8 дахь заалтын “энэ хуулийн 29.1.2-т заасан” гэснийг “хотын өмчит болон хотын өмчийн оролцоотой” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

34.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 17.1.6 дахь заалтын “бүтээн байгуулалтын” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

35.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.1.Энэ хуулийн 18.2-т заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар зохицуулна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

36.Төслийн 18 дугаар зүйлийн 18.2.5, 18.2.6, 18.2.14 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

37.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “хот хөгжүүлэх” гэсний дараа “сан, хотын дэд бүтцийн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

38.Төслийн 20 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

39.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Учрал гишүүн. Би юу? Минийх болсонгүй юу? Би уг нь дэмжсэн юм байгаа юм. Тэгсэн болсонгүй. Санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал гаргаж байна.

Саналыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал хүчингүйд тооцогдлоо.

Санал хураалт, дахин санал хураалт явуулъя.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ. 40.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн 22 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Байхгүй. Алга байна.

40.Төслийн 23 дугаар зүйлийн “паркийг” гэснийг “парк, гаалийн тусгай бүсийг” гэж, мөн хэсгийн “заасан журмын дагуу” гэснийг “заасны дагуу” гэж өөрчилж, 23.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

44.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “Зөвлөлийн шийдвэрээр” гэснийг “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1.8-д заасны дагуу” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

42.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.1.3.хотын өмчит болон хотын өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хотод ногдох ногдол ашгийн 10 хүртэлх хувь;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

43.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.4, 25.1.5, 25.1.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

44.Төслийн 25 дугаар зүйлийн 25.2.1 дэх заалтын “инженерийн болон” гэснийг хасаж, 25.2.2 дахь заалтын “түүх, соёлын” гэсний дараа “өвийг хадгалан

хамгаалах,” гэж, 25.3 дахь хэсгийн “санг байгуулах” гэсний дараа “түүний удирдлага, зохион байгуулалт,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

45.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “эх үүсвэрээр” гэсний дараа “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийлүүлэн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.5 дахь хэсэг нэмэх:

“27.5.Хөрөнгө оруулалтын хэлбэр, татварын болон татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

47.Төслийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн эхний өгүүлбэрийг “28.1.Хотод хэрэгжүүлэх төсөл нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 16.1.2, 16.1.3, 16.1.4-т заасан шалгуур хангасан тохиолдолд дараах хугацаагаар тогтвортжуулалтын гэрчилгээг олгоно.” гэж, 28.6 дахь хэсгийн “өөрөөр заагаагүй бол” гэснийг “заасан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

48.Төслийн 28 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 28.7 дахь хэсэг нэмэх:

“28.7.Хотод үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээртэй хамтран ажиллах зорилгоор хөрөнгө оруулагчдын төлөөллөөс бүрдсэн Хөрөнгө оруулагчдын зөвлөлийг хотын Захирагчийн дэргэд байгуулах ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хотын Зөвлөл батална.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

49.Төслийн 29 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Алийг? Хураачихсан, хураачихсан.

49.Төслийн 29 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

50.Төслийн 30 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

51. Төслийн 32 энэ 31 юм байна тийм үү? 31.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн 31 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

51. Төслийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

52. Төслийн 33 дугаар зүйлийн гарчгийн “этгээдийн” гэсний дараа “эрх,” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.1 дэх хэсэг нэмэх:

“33.1. Хот төлөвлөлтийн бичиг баримтаар зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр бүсчлэлийн дүрмийн дагуу хэрэгжүүлэх эрхтэй.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

53. Төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн “Иргэний хуульд” гэснийг, мөн зүйлийн 34.3, 34.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

53. Төслийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн “Иргэний хуульд” гэснийг, мөн зүйлийн 34 хураачихсан байна тээ?

54. Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.1. Энэ хуулийг 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн энэ хуулийн 14.2-т заасан нөхцөл бүрдэж, хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

За тэгье.

55. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

1. Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “бүтээн байгуулах” гэсний өмнө “төлөвлөх,” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалтын “нийтийн” гэсний өмнө “олон” гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “бүтээн байгуулалт” гэсний өмнө “төлөвлөлт” гэж, 10 дугаар зүйлийн 10.1, 10.6 дахь хэсгийн, 17 дугаар зүйлийн

17.1.2 дахь хэсгийн “хөгжлийн” гэсний дараа “ерөнхий төлөвлөгөө” гэж, 10 дугаар зүйлийн 10.5.2 дахь заалтын “хэрэгжүүлж” гэсний өмнө “төслийг” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “чиг үүргээс” гэсний өмнө “нийтлэг” гэж тус тус нэмэх.

2. Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “Засгийн хуралдаанд” гэснийг “Засгийн газарт” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.14 дэх заалтын “нийтийн үйлчилгээний” гэснийг “олон нийтийн” гэж, 10.7 дахь хэсгийн “үүсэн” гэснийг “үүссэн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “хотын” гэснийг “хот” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “гүйцэтгэнэ” гэснийг “хэрэгжүүлнэ” гэж, 15 дугаар зүйлийн гарчгийн “зөвлөл, түүний” гэснийг “зөвлөлийн” гэж, 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийн “бүрэн эрхийг” гэснийг “эрх, үүргийг” гэж, 16.7.18 дахь хэсгийн “10.4” гэснийг “10.3” гэж, 18 дугаар зүйлийн 18.2.3, 18.2.4 дэх хэсгийн “байгууламж,” гэснийг “байгууламжийн” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “үйлдвэр” гэснийг “үйлдвэрлэл,” гэж, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “тогтвортжуулалтын” гэснийг “тогтвортжуулах” гэж, мөн хэсгийн “зохицуулаагүйгээс” гэснийг “зохицуулснаас” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Санал бүрээр хэлэлцэнэ гэсний дагуу явж байгаа шүү.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, /Шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Ажлын хэсгийн санал.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Нэг. Улсын зэрэглэлтэй хот” гэсэн хэсгийн 4 дэх заалтыг бүхэлд нь хассугай.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

“Хархорум хотын талаарх авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу?

Ажлын хэсгийн санал байгаа юм байна.

1.Төслийн гарчгийг “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” гэж өөрчилж, тогтоолын үндэслэх хэсгээс “, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь” гэснийг хасаж, төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Л.Оюун-Эрдэнэд даалгасугай:

1.“Хархорум” хотын бүтээн байгуулалтын үйл ажиллагааг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн зохион байгуулах;

2.“Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны төсөв, хөрөнгө, эрх, үүрэг, бүтэц бүрэлдэхүүнийг Хархорум хотын Захирагчийн ажлын албанад шилжүүлэх.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дэх заалтыг хасаж, үүнтэй холбогдуулан тус заалтыг агуулгыг алдагдуулахгүйгээр “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүнээс 8 гишүүн санал хураалтад оролцож, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

“Хархорин хотын талаарх авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу?

Алга байна.

“Хархорум хотын эдэлбэр газрын хил, заагийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу?

Алга байна.

“Хархорум бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ?

Сандаг-Очир гишүүн танилцуулъя.

Хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

17.48 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР